

# “Үйл явдал” НОМ

2-р хичээл

Бүтэц ба агуулга

Эх бичвэр



thirdmill

Biblical Education. For the World. For Free.

© 2012 by Гурав дахь мянган үйлчлэл

Зохиогчийн бүх эрх хуулиар хамгаалагдсан. Энэ хэвлэлийн ямар ч хэсгийг ашиг олохын төлөө ямар нэгэн хэлбэрээр өөрчлөхийг хориглоно. Харин дүгнэлт бичих, санал өгөх, эрдэм шинжилгээний зорилгоор хэсэгчлэн эш татахад зохиогчийн эрхийг эзэмшигчээс бичгээр зөвшөөрөл авахыг шаардахгүй, Third Millennium Ministries, Inc., 316 Live Oaks Blvd., Casselberry, Florida 32707.

Энэхүү материалыг 2007 онд Ийгли ТВ-н Христийн Нэвтрүүлгийн албанд орчуулсан бөгөөд Библийн зарим эшлэлүүдийг Монголын Библийн Нийгэмлэгийн Шинэ Гэрээ©1990 номноос зохиогчийн зүгээс Ийгл ТВ-ын Христийн нэвтрүүлгийн албанд өгсөн зөвшөөрлийн дагуу оруулсан. Библийн бусад эшлэлийг Ариун Бичээс Нийгэмлэгийн Ариун Библи ©2004-ээс авлаа.

### ГУРАВ ДАХЬ МЯНГАН ҮЙЛЧЛЭЛИЙН ТУХАЙ

дахь мянган үйлчлэл нь 1997 онд үүсгэн байгуулагдсан, ашгийн бус, Христитгэлийн Сайнмэдээний үйлчлэл бөгөөд дараах талбаруудад чиглэдэг:

#### **Библийн боловсролыг. Бүх дэлхийд. Үнэгүй.**

Бидний зорилго бол үйлчлэлд нь тохирсон сургалт хэрэгтэй байгаа зуу зуун, мянга мянган пастор, удирдагч нарт Христитгэлийн боловсролыг үнэгүй олгох явдал юм. Бид энэхүү зорилгодоо хүрэхийн тулд олон нийтийн мэдээллийн хэрэгслийг ашиглан, дахин давтагдашгүй, цуврал хичээлүүдийг Англи, Араб, Мандарин, Орос болон Испани хэл дээр бэлтгэн дэлхий дахинд түгээж байна. Мөн манай хөтөлбөрүүд хамтран ажилладаг үйлчлэлүүдээр маань дамжуулан өөр олон орны хэл уруу орчуулагдаж байгаа билээ. Хөтөлбөр бүр зурагт мэдээлэл бүхий бичлэг, дүрст заавар болон цахим эх сурвалжуудаас бүрдсэн байдаг. Эдгээр нь сургууль, бүлгүүд, хувь хүмүүс танхимаар болон цахимаар ашиглахад зориулагдсан болно.

Дээд зэргийн агуулга болон чанартай шилдэг олон нийтийн мэдээллийн хэрэгсэл бүхий хичээлүүдийг хамгийн хямд зардлаар бүтээх аргыг бид олон жилийн хугацаанд боловсруулсан. Манай зохиолч, хянан тохиолдуулагчид теологийн мэргэжлийн сургагч багш нар байдаг бөгөөд орчуулагчид нь орон нутгийнхаа унаган хэлтэй теологийн мэдлэгтэй хүмүүс байдгаараа давуу талтай. Мөн дэлхийн өнцөг булан бүрийн нэр хүндтэй эрдэмтэд болон номлогчдын үг манай хичээлүүдэд гүн шингэсэн байдаг. Үүнээс гадна зураглаач болон эх бэлтгэгч нар маань мэргэжлийн түвшний тоног төхөөрөмж болон арга хэрэгслийг ашиглан өндөр чанарын бүтээл гаргахаар зорьдог билээ.

Бүтээлүүдээ дэлхий дахинд түгээхийн тулд Гурав дахь мянган үйлчлэл нь сүм чуулганууд, сургалтууд, Библийн сургуулиуд, илгээлтийн эзэд, Христитгэлийн нэвтрүүлэгчид болон өргөн нэвтрүүлгийн сувгууд гэх мэт олон төрлийн байгууллагуудтай бодлогын түншлэлийг бий болгосоор ирсэн. Энэхүү бодлогын түншлэлийн үр дүнд тоо томшгүй олон дүрст бичлэг бүхий хичээлүүд нь орон орны уугуул удирдагч нар, пасторууд болон оюутнуудад хүрчээ. Мөн бид цахим хуудсаараа дамжуулан суралцах бүлгээ хэрхэн эхлүүлэх зэрэг хичээлүүдийг баяжуулах нэмэлт хэрэглэгдэхүүнүүдийг тараан түгээсээр байна.

Гурав Дахь Мянган Үйлчлэл нь татвараас чөлөөлөгдөх зөвшөөрөлтэй (IRS as a 501(c) (3) corporation). Бид сүм чуулганууд, сангууд, аж ахуйн нэгж болон хувь хүмүүсийн татвараас чөлөөлөгдсөн өгөөмөр хандиваар үйл ажиллагаагаа явуулдаг. Манай үйлчлэлийн тухай болон хамтран ажиллах талаар дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл [www.thirdmill.org](http://www.thirdmill.org) цахим хуудсаар зочлоорой.

# Агуулга

<b>УДИРТГАЛ .....</b>	<b>1</b>
<b>Уран яруу өгүүлэх арга барил .....</b>	<b>1</b>
Илэрхийлсэн зорилго.....	2
Түүхэн баримт .....	2
Сайн мэдээ .....	3
Эрх мэдлийн хараат байдал .....	5
Үгс .....	5
Үйл хэрэг .....	7
Бүтцийн загвар.....	8
Хураангуй мэдээлэл.....	8
Христэд итгэгчдийн өсөлт .....	9
<b>Агуулга.....</b>	<b>10</b>
Иерусалим хот.....	12
Иудей, Шомрон аймаг .....	13
Энэ дэлхийн өнцөг булан бүрт .....	14
Сирийн Фойних аймаг, Кипр арал, Антиох хот.....	14
Кипр арал, Фрууг, Галат аймаг .....	15
Бага Ази, Македони, Ахай аймаг .....	15
Ром хот.....	16
<b>Орчин үеийн хэрэгжүүлэлт .....</b>	<b>17</b>
Утга зохиолын шинж чанар .....	17
Сонгосон .....	18
Хэсэг хэсгээс бүрдсэн.....	18
Далд хэлбэрээр заасан .....	19
Үл үргэлжилэх зүйлс .....	21
Өөр цаг үе .....	21
Өөр нөхцөл байдал.....	22
Үргэлжилэх зүйлс .....	23
Нэг л Ертөнцийн Эзэн .....	23
Нэг л зорилго.....	24
Нэг л Сайн мэдээ.....	25
<b>ДҮГНЭЛТ.....</b>	<b>25</b>
<b>ТАЙЛБАР ТОЛЬ.....</b>	<b>26</b>

# “Үйл явдал” ном

## Хоёрдугаар хичээл

### Бүтэц ба агуулга

#### УДИРТГАЛ

---

Нэгэнт л багш хүн болохоор заримдаа надад дэлхийн олон оронд очих боломж гардаг юм. Харин би үргэлж аялал бүрийнхээ өмнө хоёр чухал зүйлийг мэдсэн эсэхээ шалгадаг. Нэгдүгээрт би хаашаа явах гэж байгаагаа мэдэж авдаг. Харин хоёрдугаарт нь тийшээ яаж явах гэж байгаагаа мэдэх хэрэгтэй болдог. Нисэх онгоцоор явах уу? Автобусаар явах юм уу? Эсвэл тээврийн бусад хэрэгслэл ашиглах болов уу гэх мэтийн асуулт гарч ирдэг. За харин бид “Үйл явдал” номыг уншиж байхдаа яг үүнтэй төстэй зүйлийг хийх хэрэгтэй болдог юм. Энэ бүхэн бидэнд Үйл явдал номын түүх хаашаа өрнөж байгаа болон тэр чиглэл рүү хөтлөн аваачихын тулд Луух утга зохиолын ямар арга барил буюу стратеги хэрэглэж байгааг мэдэхэд тусалдаг.

Энэ бол “Үйл явдал” номоор заах цуврал хичээлийн маань хоёр дахь нь юм. Бид эдгээр цуврал хичээлээр анхны итгэгчид Есүсийн үйлчлэлийг хэрхэн үргэлжлүүлж байгааг судалж байгаа билээ. Луух цуглуулсан материалаа, бусдад заахыг хүссэн сургаалаа хэрхэн эмхэтгэн цэгцэлж оруулсаныг судлах учраас энэ хичээлийг “Бүтэц ба агуулга” гэж нэрлэлээ.

Бид Үйл явдал номын бүтэц ба агуулгыг гурван хэсэгт хувааж судлана. Эхлээд бид Үйл явдал номыг бичихдээ Луухын хэрэглэсэн чиг хандлага нь үүнийг тайлбарлахад хэрхэн нөлөөлж байгааг үзэж, уг номын уран яруу өгүүлэх арга барилыг судлана. Хоёрдугаарт, бид уг номын агуулгыг судалж, үүний материалыг эмхлэн оруулсаныг харж, энэ бүхнийг нэгдүгээр зууны үед хэрхэн ойлгож байсныг авч үзэх болно. Гуравдугаарт, бид эрт дээр үед бичсэн Луухын сургаал нь өнөөгийн бидэнд хандаж хэрхэн эрх мэдэлтэй үг хэлж байгааг тунгаан бодож уг номыг орчин үеийн хэрэгжүүлэлтийн загвар болгохыг санал болгоно. За одоо бүгдээрээ эхлээд Үйл явдал номын уран яруу өгүүлэх арга барилыг судалцгаая.

#### УРАН ЯРУУ ӨГҮҮЛЭХ АРГА БАРИЛ

---

Бид Библийн аль нэг номыг уншихдаа тухайн зохиогч уншигчиддаа үзэл бодлоо хүргэхийн тулд ямар арга хэрэглэж байгаа мэдэх нь чухал байдаг. Бид “Зохиогч энэ номыг яагаад бичсэн юм бэ? Тэрбээр бичсэн үндэслэлээ тогтоохын тулд ямар эрх мэдлээр хандсан байдаг вэ? Мөн уншигчиддаа үнэн зөв дүгнэлт гаргахад чиглүүлэхийн тулд номоо ямар бүтэцтэй бичсэн бэ?” гэх мэт асуултыг тавих хэрэгтэй болдог. Эдгээр асуултын хариултауд нь бидэнд хэзээ ч үл хэрэгсэж болохгүй олон гүн гүнзгий ойлголтыг өгдөг юм.

Бид Үйл явдал номыг авч үзэхдээ Луухын хэрэглэсэн уран яруу өгүүлэх арга барилын гурван талд нь гол анхаарлаа хандууулна. Нэгдүгээрт, бид түүний илэрхийлсэн зорилгын тухай ярилцана. Хоёрдугаарт, бид түүний эрх мэдлийн хараат байдлын тухай өгүүлнэ. Харин гуравдугаарт, бид уг номын турш түүний хэрэглэсэн бүтцийн зарим нэг загварын талаар ярина. Одоо бүгдээрээ Үйл явдал номыг бичихдээ Луухын илэрхийлсэн зорилгын талаар үзэцгээе.

## ИЛЭРХИЙЛСЭН ЗОРИЛГО

Ер нь хүмүүс нэлээд урт, нарийн төвөгтэй номыг бичихдээ ихэвчлэн олон санаа бодол зорилго агуулсан байдаг. Луух ч гэсэн Сайн мэдээ ба Үйл явдал гэсэн хоёр боть ном бичихдээ бас тийм байсан. Тэрбээр өөрийнх нь бичсэн ном Тёфил болон Христэд итгэгчдэд маш олон талын нөлөө үзүүлнэ гэж найдаж байжээ. Тиймээс бид түүний бичсэн зорилгыг хөнгөн хуумгай үзэж болохгүй. Луух бүтээлдээ ийм зорилготой гэдгээ тодорхой илэрхийлсэн байдаг.

Луух энэ бүгдийг бичиж байхдаа тавьсан зорилгоо хоёр талтай гэдгийг тодорхой хэлж байсан талаар бид үзнэ. Юуны өмнө 1-р зууны үеийн Христэд итгэгчдийн тухай үнэн зөв найдвартай түүхэн баримт бичих хүсэл байсан гэдгээ Луух тунхагласан байдаг. Мөн тэрбээр теологийн хувьд маш чухал бодолтой байсан гэдгээ дурдсан. Өөрөөр хэлбэл Христийн тухай сайн мэдээний үнэнийг баталж ач холбогдлыг нь бусдад дамжуулах хүсэлтэй байжээ. Бид түүхэн үнэн зөв баримтыг бичих гэсэн Луухын санаа бодлоос эхлээд энэ зорилгын хоёр талыг хоёуланг нь үзнэ.

## Түүхэн баримт

Луух өөрийн бичсэн Сайн мэдээний номныхоо 1-р бүлгийн 1-ээс 3-т анхны итгэгчдийн тухай үнэн түүхийг бичихийг үнэхээр их сонирхож байгаагаа харуулсан байдаг. Түүний хэлсэн үгийг сонсоцгооё:

Гүнээ хүндэт Тёфил ээ! Бидний дунд Есүс Христийн бүтээсэн гайхамшгийг үзсэн хүмүүс энэ тухайгаа бидэнд ярьж өгснөөр барахгүй зарим нь бүр ном бичжээ. Би олон жил үүнийг сайн судалсан учраас сонссон бүхэн чинь үнэн болохыг танд ойлгуулахыг зорьж, тун сонирхолтой нэгэн өгүүлэлийг дэс дараалан бичиж өгье (Луух 1:1-3).

Үнэн түүхийг бичих гэсэн Луухын сонирхол энэ хэсэгт хэдэн удаа илт харагддаг. Тэрбээр “Бидний дунд Есүс Христийн бүтээсэн” гайхамшгийн тухай дурджээ. Энэ бол үнэхээр болж өнгөрсөн түүхэн үйл явдал юм. Луух бас энэ бүхнийг “үзсэн хүмүүсээс” асууж лавласан бөгөөд бичсэн зүйлээ “сайн судалсан” аж. Мөн тэрбээр үүнийгээ ихэд анхаарч “дэс дараалан бичиж” өгсөн тул түүний мэдээлсэн үнэн нь хүмүүст тун тодорхой, ямар ч алдаа мадаггүй хүрсэн байна.

Товчхон хэлэхэд, Луух “Сайн мэдээ” болон “Үйл явдал” гэсэн хоёр боть бүтээлдээ түүхэн үнэн бодит баримтыг оруулахыг хүсчээ. Тэрбээр Сайн мэдээндээ Есүсийн амьдралыг бичиж эхэлсэн бол Үйл явдал номоо 1-р зууны үеийн итгэгчдийн тухай бичиж үргэлжлүүлсэн байна. Ертөнцийн Эзэн Өөрийгөө үнэн түүх, жинхэнэ орон зай, бодит цаг хугацааны дунд илчлэн харуулдаг гэж Библид дахин дахин өгүүлдэг үндсэн зарчмыг Луух ойлгосон учраас л үнэн бодит түүхийг бичиж тэмдэглэхийг хүсчээ. Ертөнцийн Эзэн хүн төрөлхтний түүхийн турш аврал болон шийтгэлээ харуулсаар ирсэн юм.

Харамсалтай нь, ойрын хэдэн зууны турш олон шүүмжлэгч эрдэмтэн “аврал”, “шийтгэл” зэрэг ойлголт нь хүн төрөлхтний бодит түүхтэй огт хамаагүй алдаатай үзэл гэж маргалдах болов. Ерөнхийдөө тэд Ертөнцийн Эзэн ер бусын үйл хэрэг нь хүн төрөлхтний түүх, бодит орон зай цаг хугацаанд огт болоогүй гэж нотлохыг хичээдэг. Тэд жинхэнэ түүх бол ер бусын бус энгийн байдаг гэж үздэг. Үүнээс болоод шүүжлэлт теологчид Библид буй Ертөнцийн Эзэний үйл хэргийн тухай уншихдаа эдгээрийг “сүсэгтний хуурамч зохиол”-ын төрөлт багтах баримтат бус шашины уянгын халилын илэрхийлэл мэт боддог.”

Харин Луух үүгээрээ сүсэгтний хуурамч зохиол бичих бус, үнэн бодит түүхийг мэдээлэх санаатай байсан гэдгээ тун тодорхой харуулдаг. Үнэндээ тэрбээр өөрийнх нь бичсэн бүгдийг тун амархан шалгаж эсвэл няцааж болох байдлаар бичсэн юм. Жишээлбэл, Луух мэдээ баримтаа олны сайн мэдэх түүхэн нөхцөл дундаас гаргаж ирсэн байдаг. Үйл явдал номноос хэдэн жишээ авъя. Бид 5-р бүлгийн 34-т Гаамалиель багш, 28-р бүлгийн 12-т Галион гэдэг хүн, 3-р бүлгийн 26-д Фээлих захирагч, 24-р бүлгийн 27-д Порхфээст захирагчийн тухай уншиж болно. Эд бол эртний Еврей болон Ромчуудын дунд нэрд гарсан хүмүүс байв. Луух эдгээр болон бусад түүхэн хүмүүсийн тухай дурдсанаараа уншигчиддаа өөрийнх нь судалгааг бие дааж шалгах боломж олгосон байна. Тэд түүний бичсэн хүмүүс болон үйл явдлын тухай мэдэх бусад улсуудтай ярилцаж, зарим нэг тохиолдолд бол яг адилхан сэдвээр өөр хүмүүсийн бичсэн бичиг зохиолыг уншиж болох байлаа. Хэрэв Луухын бичсэн бүхэн үнэн баримтанд тулгуурлаагүй бол үл итгэгчид тэр бүхнийг тун амархан үгүйсгэж чадах байсан билээ.

Ялангуяа 19-р зууны сүүл үеэс нэлээд хэдэн эрдэмтэн Үйл явдал номын үнэн зөв эсэхийг библийн холбогдолтой олон бичвэр болон археологийн бусад мэдээ баримттай харьцуулан шалгаж үзжээ. Эдгээрээс олонхи нь Луух бол найдвартай түүхч гэдгийг хэд хэдэн аргаар харуулсан байдаг. Харин бид цаг бага байгаа учраас зөвхөн хоёр онцгой жишээг авч үзнэ.

Эхлээд Үйл явдал номын 28-р бүлгийн 7-д Луух түүхийн тусгай нэр томъёоны талаар мэдлэгтэй болохоо хэрхэн харуулсаныг үзэцгээе. Тэрбээр энд Мальт арлын захирагчийг “арлын тэргүүн” буюу Грекээр “прото тес несоу” гэж хэлсэн байдаг. Энэ хачин үг зуун зууны турш Библи тайлбарлагчдыг гайхшруулж байлаа. Харин саяхан хийсэн археологийн судалгаагаар энэ нь тухайн үеийн захирагчийн албан ёсны нэр байсныг баталсан байна.

Хоёрдугаарт, Луух Үйл явдал номын 27-р бүлгийн 21-26-д усан онгоцон дээр хийсэн Пуулийн үйлдлийг дурдсан билээ. Энэ ч мөн адил түүхийн судалгаагаар нотлогджээ. Тэр хэсэгт Пууль өөрийг нь Ром хот руу хүргэж байгаа хөлөг онгоцны багийнханд далайн аймшигт шуургатай тулгарахад нь зөвлөгөө өгч урамшуулан зоригжуулсан үг хэлсэн тухай гардаг. Пууль хоригдол байсан учраас олон түмэнд

хандаж ингэж нээлттэй үг хэлэх боломжгүй хэмээн олон шүүмжлэлт эрдэмтэн урд нь үздэг байв. Тэгээд тэд Луух нь Есүсийн төлөөлөгч хүний баатарлаг зохиомол дүрийг бүтээжээ гэдэг дүгнэлт гаргажээ. Харин саяханы судалгаагаар 1-р зууны үеийн далайн хуулиар тухайн усан онгоц маш аюултай байдалд орсон тохиолдолд хөлөг дээр байгаа ямар ч хүн үг хэлж зөвлөгөө өгөхийг зөвшөөрдөг байсныг олж тогтоожээ.

Эдгээр жишээ нь түүхэн баримтанд Луух яв цав нийцүүлж байсныг харуулж байна. Түүхэн бодит үйл явдлуудын тухай бичих гэсэн түүний санаа нь бидэнд Ертөнцийн Эзэн бол ямар нэгэн байдлаар бодит амьдралаас хол хөндий байдаггүй юм гэсэн мөнхийн үнэнийг сануулж байна. Тэгээд ч аврал нь бодит түүхээр дамжин ирдэг гэсэн библийн үнэн байдаг билээ. Луух түүхэн үнэн баримтан дээр тулгуурлаж бичихийг маш их хүсэж байсан нь ийм учиртай юм.

## Сайн мэдээ

Бид Луухын түүхэн зорилгыг тунгаан бодож байгаад түүний гаргах санааны хоёрдахь талыг үзэцгээе. Энэ бол сайн мэдээний бодит үнэн болон хүч чадлыг дамжуулах гэсэн теологийн зорилгыг Үйл явдал номонд хэрхэн оруулсан тухай юм. Бүгдээрээ Луухын үгийг уг номын 1-р бүлгийн 3, 4-р ишлэлээс дахин нэг сонсоцгооё. Тэнд:

. . . сонссон бүхэн чинь үнэн болохыг танд ойлгуулахыг зорьж, тун сонирхолтой нэгэн өгүүлэлийг дэс дараалан бичиж өгье (Луух 1:3-4).

Бидний энд харж байгаагаар бол Тёфил болон бусад хүнд заасан бүхнээ үнэн гэж батлахын тулд Луух Үйл явдал номонд буй түүхүүдийг бичсэн ажээ. Тэгэхлээр магадгүй Үйл явдал номыг асуулт хариултын хэлбэрээр буюу сурган заах маягаар бичсэн гэж тодорхойлох нь арай зөв байх болов уу. Луух Тёфил болон бусад уншигчидаа тухайн нэг үзэл бодол, теологийн итгэл үнэмшил болон Үйл явдал номонд мэдээлсэн түүхэн явдлын теологийн ач холбогдолд хандах тодорхой хандлагатай байхыг хүсэж байв.

Бидний өмнөх хичээлээр үзсэнчлэн Луух орчлон хорвоо болон хүн төрөлхтний түүхийг Христ Их Эзэн болж ер бусын хаант улсаа байгуулж байгаагаар л зөвхөн харж байсан билээ. Тэрбээр Хуучин Гэрээний найдвар, мөн амлалтууд нь Христ болон түүнд итгэгчидээр дамжин биелэж байгааг олж харжээ. Тийм учраас л тэрбээр эхэн үеийн Христийн сүмийн тухай мэдээ баримтыг нь Тёфил мөн ийм л нүдээр харж, Христ хэрхэн энэ ер бусын хаант улсыг Ертөнцийн Эзэний Сүнсээр дамжуулан эхэлж, улмаар үргэжлүүлэн байгуулсаар байгааг ойлгоосой гэж хүссэн. Тийм учраас өнөө үед бид энэ номыг уншиж байхдаа Луух зөвхөн бидний мэдэж авбал зохих олон жилийн өмнө болсон үйл явдлын үнэн баримтыг бичиж тэмдэглээгүй юм гэж үргэлж бодож байх хэрэгтэй. Харин ч тэрбээр Ариун Сүнсний тусламжтай үргэжилсээр байгаа Христийн ажлын найдвартай гэрч болох Түүний сүмийн үндэс болсон сургаалуудад анхаарал хандуулсан байдаг.

## ЭРХ МЭДЛИЙН ХАРААТ БАЙДАЛ

Нэгэнт бид Луухын илэрхийлсэн зорилгын хоёр талыг үзсэн болохоор одоо түүний уран яруу өгүүлэх арга барилын хоёр дахь хэсэг болох эрх мэдлийн хараат байдал гэсэн сэдвийг үзэхэд бэлэн боллоо. Луух түүхэн болон теологийн үнэнээ өөрийн эрх мэдлээр бус, Христ ба Түүний төлөөлөгчдийн эрх мэдэл дээр үндэслэн нотолсон юм. Ийм байдлаар Луух Христийн тухай сайн мэдээний жинхэнэ гэрчийн үүрэг гүйцэтгэсэн байна.

Христийн тухай гэрчлэн ярьж байсан гол хүмүүсийн үг яриа, үйл хэрэгт нэлээд их хэсгийг зориулсан нь Үйл явдал номын нэг гайхалтай тал юм. Христ дээш тэнгэрт одохын өмнө Төлөөлөгчдөө гол гэрчлэгч болгон нэрлэж, Өөрөөс нь хамааралтай байж ер бусын улсыг нь үргэлжилүүлэх эрх мэдэл олгосон билээ. Тэрбээр тодорхой хугацааны явцад зарим нэг зөнч болон Христийн сүмийн алдартай удирдагчдад Өөрийнхөө үгийг тунхаглах эрх олгож байв. Төфил болон сүмийн энгийн олон түмнийг ятган сэнхрүүлж байсан Луух өөрийн үзэл бодлоо дүрслэн харуулж, хүлээн зөвшөөрүүлэхийн тулд эхэн үеийн итгэгчдийн удирдагчид, ялангуяа Есүсийн төлөөлөгчид болон зөнчдийн тухай дахин дахин дурдсан байдаг.

Луух хэрхэн бусад эрх мэдлээс хараат байсныг илүү нарийвчлан судлахын тулд бид хоёр зүйл дээр гол анхаарлаа хандуулах болно. Нэгдүгээрт, бид Луух хэрхэн эрх мэдэлтэй үгээр бичихийг хүсэж байсныг авч үзнэ. Хоёрдугаарт, тэрбээр хэрхэн эрх мэдэлтэй үйл хэргийг чухалчилж байсныг харна. Бүгдээрээ Христэд итгэгчдийн дунд эрх мэдлийг агуулсан үгсийг Луух хэрхэн анхаарч байсныг үзэцгээе.

## Үгс

Бид өмнөх хичээл дээр Луух нь Есүсийн томилсон төлөөлөгчдийн нэг байгаагүй гэдгийг дурдсан. Тэрбээр Христийг тэнгэрт одсоны дараа Түүнд итгэсэн бололтой. Луух Пуультай болон бусад хүнтэй аялаж явахдаа Есүсийн үйлчлэлийг, Түүний төлөөлөгчдийн ажил үйлсийг нарийн судалж, Их Эзэний сонгосон гэрч нарын үгийг бичиж тэмдэглэжээ.

Гэхдээ нэг талаар бол Христийн бүх дагалдагч нь Түүний гэрч болдог билээ. Харин итгэгчид бий болж сүм байгуулагдах үед Есүс төлөөлөгчдөө найдвартай гэрч болох эрх өгсөн юм. Тэд бол Түүнийг байхгүй үед энэ дэлхий дээр үргэлжийн эрх мэдэлтэй гэрч байх эрх мэдлийг авч томилогдсон билээ. Мөнх Их Эзэн маань зарим нэг тохиолдолд зөнчид болон Луухтай адил сүмийн удирдагчдад Өөрийнх нь тухай эрх мэдэлтэй гэрчлэн ярих эрх олгодог байв.

Эрх мэдэлтэй үгсийг бусдад танилцуулахдаа Луухын ашигласан хамгийн онцгой арга бол хүмүүсийн яриа хөөрөөг бичиж тэмдэглэсэн явдал юм. Луух зөвхөн сүмд зааж буй сургаалийг бичихийн оронд Их Эзэний эрх мэдэлтэй хүмүүс өөрсдөө Түүний түүхийн идэвхтэй оролцогч болж байгааг харуулсан тэдний яриаг олон удаа оруулсан байдаг.

Үнэндээ бол Үйл явдалын номын 30% нь маргаан, харилцан яриа,



ганцаарчилсан яриа, номлол, болон аман танилцуулгын бусад хэлбэрээс бүтдэг. Магадгүй энэ ном нь эрт дээр үеийн хүүрнэл зохиолууд дотроос хувь хүний яриаг хамгийн их хэмжээгээр багтаасан ном байх. Учир нь Луух Есүсийн төлөөлөгчдийн эрх мэдэлд хандахыг уриалж байсан учраас яриа хөөрөөг маш чухалчлан үзсэн юм. Үйл явдал номонд нийтдээ иймэрхүү 24 яриаг бичсэн байна. Эдгээрийн 8 нь Пэтрийнх, 9 нь Пуулийнх, Стефан, Яахооб нар тус бүр нэг, үлдсэн хэдийг нь бусад хүн ярьжээ. Эдгээр яриаг ихэвчлэн Есүсийн төлөөлөгчид ярьсан байдаг. Үлдсэн цөөхөн хэдийг нь зөнчид болон тухай үеийн Христийн сүмийн алдартай удирдагчид хэлсэн байна.

Тэгвэл яагаад энэ бүх яриа нь тийм чухал байдаг юм бэ? Үйл явдал номонд буй энэ бүх яриа нь эхэн үеийн сүмийн удирдагчид хэн болох, тэд олон маргаантай асуудлын талаар ямар бодолтой байсан зэргийг бидэнд хэлж өгдөг юм. Яагаад Христийн дагалдагчид Түүний төлөө зовлон эдлэх хүсэлтэй байсныг бидэнд харуулдаг. Эдгээр яриа нь Христийн төлөө үйлчилж байсан төлөөлөгчдийн гэрчлэлийг тээж, Түүний хаант улсыг хэрхэн байгуулах зааврыг бичиж тэмдэглэсэн байдаг. Мөн эхэн үеийн Христийн сүмийн талаарх Луухын үзэл бодлыг хүчин төгөлдөр болгож байна.

Луух Үйл явдал номонд Есүсийн төлөөлөгчдийн жинхэнэ яриаг оруулсан гэдгийг хүлээн зөвшөөрдөггүй олон шүүмжлэлт эрдэмтэн 19 болон 20-р зуунд амьдарч байлаа. Эртний дэлхий дахины түүхэн тэмдэглэлүүдэд бодит баримтанд үндэслээгүй яриа хөөрөө оруулсан олон жишээ байдгийг бид хүлээн зөвшөөрөх ёстой.

Гэхдээ Луухын амьдарч байсан үед ч, түүнээс өмнө, мөн түүний дараа амьдарч байсан олон түүхч өөрсдийн бичсэн түүхэндээ жинхэнэ яриа хөөрөөг баттай оруулсан гэж бичсэнийг нэлээд хэдэн шүүмжлэлт болон библийн эрдэмтэн дурдсан байдаг. Үнэнийг хэлэхэд, бид Үйл явдал номонд буй хүмүүсийн яриаг сайтар судлавал Луухыг тиймэрхүү найдвартай түүхчдийн нэг гэдгийг батлах баримттай нотолгоог олж хардаг. Тиймээс түүний оруулсан ярианууд нь Есүсийн эрх мэдэлтэй төлөөлөгчдийн сургаалийг үнэхээр төлөөлж чаддаг юм.

Ялангуяа Луух Ариун Сүнсний оролцоотойгоор ямар ч алдаа мадаггүй эрх мэдэлтэй түүх бичсэн учраас Үйл явдал номонд буй харилцан яриануудад бид бүрэн найдаж болно. Хэдий тийм боловч одоо бид Үйл явдал номд буй харилцан ярианууд нь бодит яриа хөөрөөг тэмдэглэсэн үнэн зөв төлөөлөл гэдгийг харж болох дөрвөөс доошгүй арга замыг үзнэ.

Нэгдүгээрт, эдгээр яриа хөөрөө нь өөрийн гэсэн хэлбэртэй байв. Үйл явдал номын бусад хэсэгтэй харьцуулахад ярианууд нь зохиомол бус энгийн байв. Зарим нь бүр бүдүүн бараг энгийн хар ярианы Грек хэлээр бичигдсэн байдаг. Энэ бүхэн Луух тэдний яриаг гоёж чимж өөрчлөхөд бус, тухайн хүн яг юу гэж хэлсэнд л гол анхаарлаа хандуулж байсныг харуулж байна.

Хоёрдугаарт, эдгээр яриа нь тухайн нөхцөл байдалдаа яг нийцэж байв. Яриа бүр үүнийг хэлж буй болон сонсож буй хүмүүст яг нийцэж байлаа. Жишээлбэл, Үйл явдал номын 4-р бүлэгт Пэтр суунги хөлтэй хүнийг эдгээснийхээ дараа Иудейн удирдагчидтай ярилцсан тухай өгүүлдэг. Энд Пэтрийн хэлсэн үг нь Христэд буй авралын тухай тунхаглаж байгаа болохоор бид үүнийг Луух санаанаасаа зохиосон гэж үзэж болох ч Пэтр тэр хүнийг эдгээснийгээ өөрийнх нь хэлсэн үгийн нотолгоо гэж шууд хэлдэг. Түүгээр ч барахгүй Есүст итгээгүй Иудейн

удирдагчид хүртэл өвчтэй хүн эдгэрснийг нь өөрсдөө харсан болохоор Пэтрийн үгийг няцааж чадаагүй. Яг үүнтэй адил Пуулийн хэлсэн үг нь тухайн нөхцөл байдлыг тусган харуулж байлаа. Жишээ нь уг номын 13-р бүлэгт бичсэнээр бол Писидийн Антойч хотод Израйльчууд болон Израйль бус хүмүүст хэлсэн түүний үг нь 17-р бүлэгт буй Гүн ухааны Эпикур, Стойх бүлгийнхэнд хандан хэлсэн үгнээс эрс ялгаатай байна.

Гуравдугаарт, яриа хөөрөө бүр тухайн хүний хувь хүний онцлог шинжийг тусган харуулж байв. Хэдийгээр нийтлэг сэдвийг хамарч ярьдаг ч гэсэн өгүүлэгч бүр хувь хүний онцлог шинжээ харуулсан байдаг. Жишээлбэл, 20-р бүлэгт буй Эфэс хотын итгэгчдийн ахлагчдад Пуулийн хэлсэн үг нь түүний захидалуудын агуулгатай гайхалтай нийцдэг. Энэ бүхэн бид тухайн зохиогчийн захидалыг уншаад “Тэр хүн тэгж л ярих байх” гэсэн бодолтой маань таардаг билээ.

Дөрөвдүгээрт, Луух уг номын хэд хэдэн бүлэгт зарим нэг яриаг хураангуйлж буюу товчилж бичсэнээ тодорхой хэлсэн байдаг. Жишээлбэл, тэрбээр Үйл явдал номын 2-р бүлгийн 40-д “гэх мэтээр Пэтр өөр олон зүйл ярив” гэсэн байдаг. Энэ бүхэн биднийг жинхэнэ амьдрал дээр болсон явдлын тухай үнэн яриаг бүрэн гүйцэд бичиж танилцуулах нь Луухын зорилго байсан гэдэгт итгүүлж байна. Тэгэхлээр эдгээр болон бусад олон зүйлээс харвал Луух нь түүхэн үнэн зөв яриаг оруулсан юм байна гэдэгт бид итгэлтэй байж болох ажээ. Тэрбээр зорилгодоо нийцүүлэхийн тулд эдгээр яриаг санаанаасаа зохиож эсвэл өөрөө ургуулан бодож олоод Үйл явдал номонд бичээгүй юм. Үүний оронд тэр Есүсийн төлөөлөгчдийн жинхэнэ эрх мэдэл бүхий гэрчлэл дээр өөрийн нарийн бодож боловсруулсан санал бодлоо оруулахыг л чухалчилсан байна.

Луух иймэрхүү үгсийг бичиж тэмдэглэхээс гадна Үйл явдал номоор дамжуулан хэлсэн теологийн ойлголтуудыг дэмжих зорилгоор эхэн үеийн Есүст итгэгчдийн дунд болж байсан эрх мэдэлтэй үйл хэрэгт бас их найдлага тавьсан байдаг.

## Үйл хэрэг

Ариун Сүнс нь Есүсийн төлөөлөгчид, мөн зарим үед зөнчид болон анхны сүмийн алдартай удирдагчдад бүрэн эрх олгож маш олон гайхалтай арга замаар тэдний ярьсан сайн мэдээг хүчин төгөлдөр болгосон юм. Ийнхүү Ариун Сүнс нь гайхамшигт явдал, ер бусын авъяас чадвараар дамжуулан эдгэрэшгүй өвчнийг эдгээж үхэгсдийг амилуулсанаараа тэдгээр төлөөлөгчид бол Христээс эрх мэдэл авсан төлөөлөл мөн гэдгийг гэрчлэн харуулав.

Үйл явдал номын 13-р бүлгийн 7-оос 12-т Паф хотод нэгэн мужийн захирагчийн өмнө Пуулийн үйлчлэлийг хүчин төгөлдөр болохыг хэрхэн батлаж байгааг авч үзэцгээе. Энэ тухай Луух:

Ромын хаант улсаас томилогдсон мужийн захирагч цэцэн Сэрг-Пүүлд Ертөнцийн Эзэний тухай үнэнийг мэдэх хүсэл төрж, Барнаб, Пууль хоёрыг дуудав. . . . Барнаб, Пууль хоёрыг Есүсийн тухай ярихад Барисос бөө Сэрг-Пүүлийг Есүс Христэд итгүүлэхийг үл хүсэж,

тэднийг эсэргүүцэв. Харин Пууль Барисос бөөд хандан, ' . . . Одоо Их Эзэн чамайг шийтгэх болно. Чи одоо таг сохор болоод хойч үеийг болтол нарны гэрэл үзэхгүй' гэж хэлмэгц Барисос бөө хараагүй болж, өөрийгөө хөтлүүлэх хүнийг тэмтэрч эхлэв. Есүс Их Эзэний тухай үгийг мужийн захирагч сонсоод ихэд гайхлаа. Үүний дараа тэрээр Есүс Христэд итгэжээ (Үйл явдал 13:7-12).

Барисос бөөг Сайн мэдээнд саад хийх гэж оролдоход Ариун Сүнс түүнийг сохор болгох эрхийг Пуульд өгчээ. Пуулийн заасан сургаал болон үйлдэл нь Христийн тухай сайн мэдээ үнэн гэдэгт мужийн захирагчийг итгүүлэв.

Луух эрх мэдэлтэй үгс болон үйл хэргийг бичиж тэмдэглэсэн учраас уншигчид нь түүний тэмдэглэлийн үнэн зөвд итгэж болох байв. Тэрбээр уншигчидаа Төлөөлөгчид бол Их Эзэн Есүсээс бүрэн эрхээ хүлээн авсан болохыг ойлгоосой гэж хүссэн. Мөн бүх цаг үеийн турш дэлхий даяар оршин байсан итгэгчид нь Христээс хамааралтай байж Ертөнцийн Эзэний хаант улсыг байгуулахдаа тэдний гэрчлэлийг дагах үүрэгтэй гэдгийг ойлгуулахыг хүссэн байна.

Ийнхүү бид Луухын илэрхийлсэн зорилго болон эрх мэдлийн хараат байдал гэсэн хэсгүүдийг үзлээ. Одоо хариун Луухын уран яруу өгүүлэх арга барилын гуравдахь хэсэг болох бүтцийн загварыг үзэхэд бэлэн боллоо. Луух үүнийг мөн Үйл явдал номын турш хэрэглэсэн байдаг.

## БҮТЦИЙН ЗАГВАР

Ер нь Үйл явдал номонд бүтцийн олон загвар харагддаг. Харин бид цаг хугацааныхаа боломжоос шалтгаалаад эдгээрийн зөвхөн хоёр загвар дээр л гол анхаарлаа хандуулах болно. Нэгдүгээрт, бид дахин дахин давтагдах нэлээд содон хураангуй мэдээлэлийн загварыг судлана. Хоёрдугаарт, бид Үйл явдал номонд гарч буй Христэд итгэгчдийн өсөлтийн загварыг үзнэ. За одоо бүгдээрээ Луух иймэрхүү хураангуй мэдээлэлийг хэрхэн хэрэглэснийг үзэцгээе.

## Хураангуй мэдээлэл

Библийн зохиогчид өөрсдийгөө тухайн хүүрнэл түүхэнд янз бүрийн түвшинд илэрхийлсэн байдаг. Заримдаа бодит шалтгааны улмаас тухайн түүхийн үйл явдлын ард өөрсдийгөө нууцалдаг. Заримдаа тэд урагшаа ил гарч ирээд өөрсдөд нь тохиолдсон явдлыг өгүүлдэг. Бид зохиогчийн тайлбар гэгдэх энэ арга барилын талаар үзэх болно. Луух Үйл явдал номын турш зохиогчийн тайлбарыг олон удаа оруулсан байдаг. Тэрбээр ерөнхий мэдээлэл өгч, тэр хүмүүсийн зүрх сэтгэлийн хандлагыг илчилж, тухайн нөхцөл байдлыг дүрслэсэн. Өөрийнх нь бичсэн үг тодорхой, үнэн зөв байгаасай гэсэндээ ингэсэн билээ. Хураангуй мэдээлэл бол тухайн үйл явдлын талаар тайлбар бичих түүний нэг арга байлаа.

Үйл явдал номонд Христийн тухай сайн мэдээ Иерусалим хотоос эхлэн гадагшаа түгэн дэлгэрч байгааг маш олон уншигч анзаардаг. Харин Луух энэ

өрнөлийн явцад олон хэсэгт түр завсарлага авч байгаад тухай тухай үед нь болсон зүйлийг хураангуйлан бичсэн байдаг. Луух иймэрхүү хураангуй мэдээлэлийг уг номын турш хэрхэн хэрэгслэснийг харуулах зургаан тохиолдлыг бид судлана. Тэрбээр Христийн тухай сайн мэдээ Иерусалим хотод, Иудей болон Шомрон аймагт, Шомрон аймгаас Сирийн Антиох хотод, улмаар Кипр арал болон Фрууг, Галат аймагт, тэгээд Бага Ази, Грекийн Македони, Ахай аймагт хүрч, эцэст нь Ром хотод очиж байгааг үзүүлсэн.

Жишээлбэл, Луух Есүст итгэгчдийн амжилт болон ажил үйлсийг Үйл явдал 5-р бүлгийг 42-т:

Түүнээс хойш төлөөлөгчид Иерусалим хотын сүмийн хашаа, айл гэрт газар сайгүй очиж, Есүс бол Ертөнцийн Эзэний илгээсэн аврагч гэдгийг ярьсаар байлаа (Үйл явдал 5:42).

Луух Үйл явдал номын турш Сайн мэдээний амжилт болон Христэд итгэгчдийн өсөлтийн талаар онцлон бичихдээ иймэрхүү байдлаар хураангуйлан мэдээлдэг байлаа. Үйл явдал номын 28-р бүлгийн 30-аас 31-д бичсэн түүний тайлбарыг үзэцгээе. Тэнд:

Пууль хоёр жил байрны хөлс төлж, ирсэн бүх хүнийг хүлээн авч, Ертөнцийн Эзэний ер бусын улс болон Есүс Христ Их Эзэний тухай зоригтойгоор тунхаглахад хэн ч түүнийг хориглосонгүй ээ (Үйл явдал 28:30-31).

Тэгэхлээр Луух ингэж хураангуй тэмдэглэлээрээ бичсэн түүхийнхээ зарим нэг онцгой хэсэгт уншигчдын анхаарлыг хандуулж байна. Одоо тэгвэл бүгдээрээ эдгээр хураангуй тэмдэглэлийн хооронд үзэгддэг Христэд итгэгчдийн өсөлтийн загварыг авч үзэцгээе.

## Христэд итгэгчдийн өсөлт

Луух Есүст итгэгчдийн тоо өсөж байгаа тухай дүрслэхдээ идэвхтэй хоёр хүчийг байнга дурдаж байв. Нэг талаар тэрбээр Христэд итгэгчдийн дунд байсан зөрчил болон дотоод өсөлтийн тухай бичсэн. Нөгөө талаар Христэд итгэгчдийн гадна байсан эсэргүүцэл болон гадаад өсөлтийн тухай бичсэн байна. Бид энэ загварын талаар хичээлийнхээ төгсгөл хэсэгт дүрслэн үзүүлнэ. Харин одоо энэ нь ямар утгатай болохыг товч үзэх болно.

Бид Христэд итгэдэг хүмүүсийн дунд Сайн мэдээний үзүүлсэн эерэг нөлөөг “дотоод өсөлт” гэдэг үгээр илэрхийллээ. Үүнийг бид энэ бол хувь хүн болон бүлэг итгэгчдийг бүхэлд нь оюун санааны хувьд өсгөж өндийлгөхөд хүргэсэн чанарын өсөлтийн нэг хэлбэр байсан гэж хэлж болох байх. Харин Христэд итгэгчдийн дунд гарч байсан хэцүү байдал, төвөгтэй асуудал, санал зөрөлдөөн, бэрхшээл саадыг “зөрчил” гэдэг үгээр орлуулан хэллээ. Луух Үйл явдал номонд “дотоод өсөлт” ба “зөрчил” хоёрын хооронд харилцан хамаарал байсныг байнга харуулсан байдаг. Дотоод өсөлт нь зөрчилд хүргэж, улмаар зөрчил нь дотоод өсөлтөнд хүргэдэг аж.

Луухын бичсэн сүмийн өсөлтийн бүтцийн загварын хоёр дахь хос элемент нь гадаад өсөлт ба эсэргүүцэл юм. Бид “гадаад өсөлт” гэдэг үгээр Христэд итгэгчдийн бүлэг тооны хувьд шинэ гишүүдээр нэмэгдсэнийг хэлж байна. Энэ нь тоон өсөлтийн хэлбэр юм. Харин “эсэргүүцэл” гэдэг үгээр Христийн бүлэг ба Сайн мэдээнд таагүй хандаж буй хүмүүсээс бүрдэх үл итгэгчдийн хооронд байнга гарч байсан сөргөлдөөнийг хэлж байна. Үйл явдал номонд энэ хоёр чухал санааны хооронд бас хоёр талын холбоо байгааг дурдсан билээ. Заримдаа гадаад өсөлт нь эсэргүүцэлтэй тулгарч, улмаар ийм эсэргүүцэл нь гадаад өсөлтөнд хүргэдэг байна.

Түүгээр ч барахгүй эдгээр хос элементүүдийн хооронд харилцан холбоо байдгийг Луух олонтоо үзүүлсэн. Нэг талаас дотоод өсөлт ба зөрчлийн эсрэг гадаад өсөлт ба эсэргүүцэл тулж байна. Өөрөөр хэлбэл дотоод өсөлт болон зөрчлийн үр дүнд гадаад өсөлт ба эсэргүүцэл бий болж, улмаар гадаад өсөлт ба эсэргүүцэл нь эргээд дотоод өсөлт болон зөрчилд хүргэж байлаа. Христэд итгэгчдийн өсөлтийн ийм загвар нь Үйл явдал номонд олонтоо үзэгдэж, улмаар уг номын үзэл баримтлалын хүрээ буюу ерөнхий бүдүүвч болж байгааг бүгдээрээ дараа нь үзэх болно.

Эхэн үеийн итгэгчдийн гэрчлэлээр Христийн тухай сайн мэдээ тарж байгааг Үйл явдал номын гол хэсэг бүрт дүрслэн харуулсаныг Луух хураангуй тайлбар бүртээ бичсэн байдаг. Тэгэхлээр иймэрхүү тайлбар бүр нь Луухын номыг уншиж буй Тёфил болон бусад хүнд ямар нөлөө үзүүлж байсныг төсөөлөөд бод оо. Зөрчил тэмцэл хир их байгааг, эсэргүүцэл сөргөлдөөн ямар хэцүү байснаас үл хамаараад итгэгчид хаа ч очсон өөрсдийн хүмүүсийг гадна болон дотор талаас нь өсгөхийн тулд Ертөнцийн Эзэн Сайн мэдээг үргэлж ашиглаж байгааг хараад тэд ихэд урамшин зоригжсон байна. Эхэн үеийн Христэд итгэгчид энэ бүх түүхийг иймэрхүү хандлагаар авч үзэж байлаа. Тэд Их Эзэнийхээ, Аврагчийнхаа найдвартай гэрч нь байж чадвал гадаад болон дотоод асуудалтай байсан ч, өөрсдийн амьдарч буй үедээ ч гэсэн Христийн сайн мэдээний өсөлтийг харж чадна гэдэг итгэлтэй болсон байна.

## АГУУЛГА

---

За ийнхүү бид Луухын уран яруу өгүүлэх арга барилын зарим чухал талыг үзсэн тул хоёр дахь гол сэдвээ үзэхэд бэлэн боллоо. Энэ бол Үйл явдал номын агуулга билээ. Энэ номын агуулгыг хураангуйлж болох олон арга байдаг ч Христэд итгэгчид бий болж байгаа явдал бол газар дэлхий дээр байгуулагдаж буй Ертөнцийн Эзэний хаант улсын хэсэгчилсэн биелэлт гэж бичсэнд л гол анхаарлаа хандуулна.

Луухын бичсэн Сайн мэдээ ба Үйл явдал хэмээх энэ хоёр боть номонд Есүс энэ дэлхийд хэрхэн төрж, улмаар Сайн мэдээг тунхаглаж газар дэлхий дээр Ертөнцийн Эзэний хаант улсыг байгуулж эхэлсэнийг тайлбарладаг. Луух Сайн мэдээний номондоо Есүс дэлхий дээр амьдарч байхдаа энэ хаант улсын суурийг тавьж байгааг дүрслэн бичсэн юм. Харин Луух Үйл явдал номондоо Есүс өөрийн төлөөлөгчид болон дагалдагчиддаа Түүний хаант улсыг байгуулах ажлыг

үргэлжлүүлэх эрх мэдэл олгохын тулд хэрхэн тэдэнд Ариун Сүнсийг цутган өгч байгааг дүрслэн бичсэн. Тэгэхлээр Ертөнцийн Эзэний хаант улс гэдэг нь Луухын бичсэн хоёр дэвтэр номыг бүхэлд нь хамарсан сэдэв болж байна. Тиймээс Үйл явдал номын агуулгыг судалж байхдаа Есүсийн төлөөлөгчдийн удирдлага дор Түүний хаант улс хэрхэн өргөжин тэлж байгаад онцгой анхаарлаан хандуулах болно.

Үйл явдал номын 1-р бүлгийн 8-д Есүс өөрийн төлөөлөгчдөд үүрэг даалгавар өгөхдөө тэдэнд эхлээд Иерусалим хотод, дараа нь энэ дэлхийн бусад улс оронд Сайн мэдээг тунхаглаж, Түүний тухай гэрчлэн ярих заавар өгдөг. Бүгдээрээ Үйл явдал номын 1-ийн 8-д өөрийн төлөөлөгчдөд Есүсийн хэлсэн үгийг дахин нэг сонсоцгооё. Тэнд:

Харин түүний Ариун Сүнс та нартай нэгдсэн асар их хүч чадал өгч Иерусалим хот, Иудей, Шомрон аймаг байтугай энэ дэлхийн өнцөг булан бүрт илгээн, миний тухай яриулах болно (Үйл явдал 1:8).

Энд Христэд итгэгчид сайн мэдээг тараахдаа газарзүйн хувьд ямар стратеги баримтлахыг Есүс хэлж өгч байна. Есүсийн төлөөлөгчид Ариун Сүнснээс эрх мэдлийг хүлээн аваад Түүний тухай гэрчлэн ярих ажлаа эхлээд Иерусалим хотод, дараа нь Иудей болон Шомрон аймагт, тэгээд эцэст нь энэ дэлхийн өнцөг булан бүрт хүргэж, улмаар хаа очсон газартаа уг хаант улсыг өргөжүүлэн тэлэх ёстой ажээ.

Түүний тухай тунхаглах ажлыг өргөжүүлэхийн тулд газарзүйн хувьд ямар нутгийг хамрах талаар Есүсийн хэлсэн үгийн дагуу Луух Үйл явдал номыг эмхлэн бичсэн болохыг олон эрдэмтэн ажигласан байдаг. Бид ч гэсэн Луухын бүтээлийг судлахдаа тийм загварыг дагана. Эхлээд бид Үйл явдал номын 1-р бүлгийн 1-ээс 8-р бүлгийн 4-т Иерусалим хотод Христийн сайн мэдээ түгэн дэлгэрч байгааг Луух хэрхэн бичсэнийг судлана. Хоёрдугаарт нь бид энэ ер бусын хаант улс Иудей болон Шомрон аймагт байгуулагдаж байгааг 8-р бүлгийн 5-аас 9-р бүлгийн 31-т үзнэ. Харин гуравдугаарт бид Христэд итгэгчид Сайн мэдээг энэ дэлхийн өнцөг булан бүрт хүргэж байгааг 9-р бүлгийн 32-оос 28-р бүлгийн 31-т үзнэ. Энэ гуравдахь хэсэг нь маш урт учраас бид сая үзсэн Луухын бичсэн хураангуй мэдээлэлээс уг өсөлтийн дөрвөн үе шатанд л гол анхаарлаа хандуулах болно. Эхлээд 9-р бүлгийн 32-оос 12-р бүлгийн 25-д Сайн мэдээ Сирийн Фойних аймаг, Кипр арал, Антиох хотыг хамарч байгааг үзнэ. Дараа нь 13-р бүлгийн 1-ээс 15-р бүлгийн 35-д Кипр арлаас Фрууг, Галат аймагт тарж байгааг, тэгээд 15-р бүлгийн 36-аас 21-р бүлгийн 16-д Бага Ази, Македони, Ахай аймагт түгж байгааг үзнэ. Эцэст нь 21-р бүлгийн 17-оос 28-р бүлгийн 31-т Сайн мэдээ Ром хот хүртэл ямар замыг туулж байгааг үзэх болно.

Бид дөнгөж сая үзсэн дотоод өсөлт ба зөрчил болон гадаад өсөлт ба эсэргүүцэл гэсэн загвар дээр анхаарлаа хандуулж байгаад Луухын бичсэн энэ дөрвөн шатыг илүү нарийвчлан судлах болно. За одоо бүгдээрээ энэ ер бусын хаант улс Есүсийн төлөөлөгчдийн заасан Сайн мэдээгээр дамжин Иерусалим хотод хэрхэн байгуулагдсаныг Үйл явдал номын 1-р бүлгийн 1-ээс 8-ийн 4 хүртэлх хэсгээс харцгаая.

## ИЕРУСАЛИМ ХОТ

Иерусалим бол Хуучин Гэрээний үед Ертөнцийн Эзэний сонгон авсан онцгой үндэстэн болох эртний Израйль орны нийслэл хот байлаа. Иерусалим хот нь Хуучин Гэрээний турш Ертөнцийн Эзэний хаант улс бий болоход мөн Есүсийн үйлчлэлийн хувьд маш чухал үүрэг гүйцэтгэсэн учраас Луухын тэмдэглэлийн эхлэх цэг нь болсон юм. Түүнээс гадна шинэ газар нутагт Сайн мэдээг тарааж байсан Есүсийн төлөөлөгчдийн үйл хэрэг нь энэ онцгой хотоос эх үүсвэртэй гэдгийг дахин дахин үзүүлэхийн тулд Луух Иерусалим хотод болж байсан явдлыг уг номын нэлээд хэдэн хэсэгт бичсэн байдаг.

Луух Иерусалим хотод ер бусын хаант улс өргөжин тэлж байгааг дөрвөн хэсэг хүүрнэл түүхээр мэдээлсэн байдаг. Эхнийх нь 1, 2-р бүлэгт буй Ариун Сүнсийг горьдон хүлээж улмаар Ариун Сүнс цутган ирж байгаа хэсэг бол хоёр дахь нь 3, 4-р бүлэгт өгүүлсэн Иерусалимийн сүмд Пэтрийн заасан сургаал ба үүний дараах хавчлагын тухай хэсэг юм. Харин гуравдахь нь 5-р бүлэгт буй Ананай, Сафейр хоёрын түүх болон хавчлагын тухай хэсэг бол дөрөвдөхь нь 6-р бүлгийн 1-ээс 8-ийн 4-т гарах туслагч нарыг сонгосон болон хавчлагын тухай хэсэг юм.

жишээгээр, зэрэг Иерусалим хотод гарч байсан алдартай үйл явдлын үеэр итгэгчдийн тоо огцом өсөж байсан нь харагддаг:

- 1-р бүлэгт өгүүлсэн Есүсийн төлөөлөгчдөд өгсөн үүрэг даалгавар
- 2-р бүлэгт Пэнтээхөст баярын үеэр Ариун Сүнс цутган бууж байхад
- 3, 4, 5-р бүлэгт гарах Иерусалимд хотод болсон ер бусын гайхамшигт явдал, ялангуяа нэгэн суунги хүнийг эдгээсэн Пэтрийн явдал

Үүнтэй зэрэгцээд Христэд итгэгч хүмүүсийн дунд нэлээд хэдэн зөрчил гарсаныг бид хардаг:

- Эдгээр нь 1-р бүлэг өгүүлдэг 12 дахь төлөөлөгч хэн болох тухай асуудал
- 5-р бүлэгт буй хандивт өгсөн мөнгөнийхөө талаар Ананай, Сафейр хоёр худал хэлсэн хэсэг; болон
- 6-р бүлэгт гардаг Грек хэлээр ярьдаг бэлбэсэн авгайчуудыг ялгаварлан гадуурхахын эсрэг хэсэг зэрэг юм

Мөн Сайн мэдээ Иерусалимд хэрхэн тарж байгааг өгүүлсэн Луухын тэмдэглэлд гадаад өсөлт ба эсэргүүцлийн тухай загвар бас гардаг. Жишээлбэл:

- Пэнтээхөст баярын өдөр Христэд итгэгчдийн тоо 3000 хүнээр нэмэгдсэн тухай 2-р бүлэгт өгүүлдэг
- 4-р бүлэгт бичсэнээр бол Пэтр, Иоган хоёрыг шоронд орсоны дараа итгэгчдийн тоо 5000 хүнээр нэмэгдсэн байна, болон
- Сүмийн зэрэгтэн олон хүн Христэд итгэсэн тухай 6-р бүлэгт өгүүлжээ

Иймэрхүү гадна талын өсөлт нь үл итгэгчдийн зүгээс маш хүчтэй эсэргүүцэлтэй тулгарч байсан тухай бид үзсэн. Жишээлбэл:

- Пэтр, Иоган хоёрыг баривчилж зодсон тухай 5-р бүлэгт гардаг

- Итгэлээсээ болж Стефан алагдсан тухай 7-р бүлэгт өгүүлдэг; болон
- Хавчлагаас болж Есүст итгэгчид Иерусалим хотоос гарцгаасан тухай 8-р бүлэгт өгүүлдэг

Иймэрхүү дотоод зөрчил ба гадаад эсэргүүцэл нь Иерусалимд дөнгөж бий болж байсан Христэд итгэгчдийн бүлгийн урам зоригыг мохоосон гэж бид бодож магадгүй. Гэвч Ариун Сүнсний хүчээр бодит байдал үүний яг эсрэг байв. Сайн мэдээг гэрчлэн ярих үйл хэрэг асар хүчтэй өрнөж, улмаар үүний цаашдын өрнөлд юу ч саад хийж чадаагүй билээ.

### ИУДЕЙ, ШОМРОН АЙМАГ

Сайн мэдээг Иудей, Шомрон аймагт тунхагласан тухай 8-р бүлгийн 5-аас 9-р бүлгийн 31-т өгүүлдэг. Энэ бол Үйл явдал номонд Сайн мэдээ хэрхэн тарж байгаа явдалд анхаарлаа хандуулсан хоёр дахь томоохон хэсэг юм. Иудей болон Шомрон аймгийн нутаг нь Хуучин Гэрээний үед Израйльчуудад өгсөн Амлалтын нутгийн өмнөд болон хойд хэсэгтэй хэмжээгээрээ бараг адилхан байдаг. Есүс хүртэл тэнгэрт одохынхоо өмнө эдгээр нутгаар явж үйлчилж байсан билээ. Иудей ба Шомрон аймгийн талаар Луухын голлон анхаарсан хэсэг нь хоёр гол түүхээс бүрддэг. Эхнийх нь Үйл явдал номын 8-р бүлгийн 5-аас 40-д гарах Филиппийн үйлчлэл бол, удаах нь 9-р бүлгийн 1-ээс 31-д Пууль хэрхэн Есүст итгэсэн тухай хэсэг юм.

Энэ хоёр түүх нь Христэд итгэгчдийн дотоод өсөлтөнд голлон анхаардаг. Жишээ нь, 8-р бүлэгт бичсэнээр бол шинэ итгэгчид Ариун Сүнсээр дүүрэх бүр л дотоод өсөлт бий болж байна. Мөн 9-р бүлэгт бичсэнээр Суулийг Христэд итгэсний дараа Есүсийн нэг төлөөлөгч болгодог.

Гэхдээ энэ бүх явдалтай зэрэгцээд Есүст итгэгчдийн дунд зөрчил гарч байна. Жишээлбэл Ариун Сүнсний холбоотой төвөгтэй асуудал гарч ирсэн тухай 8-р бүлэг өгүүлдэг. Учир нь зарим итгэгчид Ариун Сүнсийг хараахан хүлээж аваагүй байв. 8-р бүлэгт Симун гэгч нэгэн бөө Есүсийн төлөөлөгчдөөс Ариун Сүнсийг худалдан авахыг оролдож байгаа тухай гарна.

Нөгөө талаар гадаад өсөлт болон эсэргүүцэл үргэлжилсээр л байлаа. Жишээ нь хэд хэдэн шалтгааны улмаас итгэгчдийн тоо эрс өссөн байна. Эдгээрээс цухас дурдвал 8-р бүлэгт өгүүлсэн Филиппийн авралын зарын ажил, болон 9-р бүлэгт гарах Пууль хэрхэн Есүст итгэсэн тухай хэсэг юм.

Гэхдээ энэ өсөлт нь үл итгэгчдийн зүгээс ирэх ямар нэгэн эсэргүүцэлгүйгээр бий болоогүй юм. Жишээлбэл, Сууль бол Есүст итгэхээсээ өмнө итгэгчдийн хавчин зовоодог хүн байсан билээ. Харин Суулийг Есүст итгэсний дараа хэдэн Иудей хүн алахыг оролдож байгаа тухай 9-р бүлэгт бас гардаг.

Дахиад л дотоод зөрчил тэмцэл, гадаад эсэргүүцэл Есүст итгэгчдэд саад болж чадсангүй. Харин үүний оронд Есүст итгэгчдийн тоо нэмэгдэж, тэднийг өсөн төлөвшихэд Ариун Сүнс эдгээр төвөг бэрхшээлийг ашигласан байна.



## ЭНЭ ДЭЛХИЙН ӨНЦӨГ БУЛАН БҮРТ

Үйл явдал номын гурав дахь гол хэсэг нь Сайн мэдээ Амласан нутгийн хил хязгаараас цааш түгэн өргөжиж энэ дэлхийн өнцөг булан бүрд буюу өнөөгийн бидний үед хэрхэн ирсэн тухай өгүүлдэг. Өмнө дурдсанчлан бид энэ хэсгийг нэлээд нарийвчлан үзнэ. Сирийн Фойних аймаг, Кипр арал, Антиох хотод Сайн мэдээ хэрхэн тарж байгааг 9-р бүлгийн 32-оос 12-р бүлгийн 25-д өгүүлсэн байдаг.

### Сирийн Фойних аймаг, Кипр арал, Антиох хот

Энэ хэсэг нь Сайн мэдээ Иудей болон Шомрон аймгаас цааш давж ойролцоох Иудей бус хүмүүсийн амьдардаг Сирийн Фойних аймаг, Кипр арал, Антиох хот хүрч өргөжин тэлж байгааг хамардаг. Бид энэ бүхнийг эхлээд Лудаа болон Яофуу хотод хийсэн Пэтрийн үйлчлэлийн тухай 9-р бүлгийн 32-оос 43-р ишлэлээс уншдаг. Дараа нь тэрбээр Цезаре хотод Хорнел гэгч Иудей бус үндэстэнд хэрхэн үйлчилсэн тухай 10-р бүлгийн 1-ээс 11-р 12-т гардаг. Тэгээд Сайн мэдээ Сирийн Антиох хот хүртэл өргөжин тэлж байгааг 11-р бүлгийн 13-аас 18-д өгүүлдэг. Мөн Пэтр Иерусалим хотод шоронгоос хэрхэн гайхалтай байдлаар чөлөөлөгдсөн тухай 12-р бүлгийн 1-ээс 25-д дурдсан байдаг.

Энд бас л нөгөө дотоод өсөлт болон зөрчлийн загвар дахин давтагдаж байгаад гайхах хэрэггүй байх аа. Луух энд дотоод өсөлт буюу Христэд итгэгчдийн тоо нэмэгдсэн талаар хэдэн жишээ оруулж өгчээ. Жишээ нь 10-р бүлэгт Еврей бус хүмүүс Есүст итгэсэн тухай өгүүлдэг. Пэтр шоронгоос гайхалтай байдлаар чөлөөлөгдсөн явдал Есүст итгэгчдийг урамшуулан зоригжуулсан тухай 12-р бүлэгт байдаг. Мэдээж энэ бүхэн бас л зөрчил тэмцэлтэй тулгарсан. Жишээ нь олон Иудей хүн Иудей бус хүмүүсийг Христийн сүмийн бүрэн эрхт гишүүн болгон хүлээн авч болох эсэхэд эргэлзэж байсныг 11-р бүлгээс харж болно. Мөн 11-р бүлэгт олон хүн Хуучин Гэрээний хоолны дэглэмийн хязгаарлалтыг сулруулахыг эсэргүүцэж байсан тухай гардаг.

Луух энэ хэсэгт гадаад өсөлт болон эсэргүүцлийн загварыг бас онцлон бичсэн. Жишээлбэл, тэрбээр гадаад өсөлт буюу Хорнел болон бусад Иудей бус олон хүн Есүст итгэсэн тухай 10-р бүлэгт өгүүлдэг. Мөн Барнаб болон бусад хүн Антиох хотод авралын зарын үр дүнтэй ажил хийсэн тухай 11-р бүлэгт гардаг. Гэхдээ энэ өсөлт ямар ч эсэргүүцэлгүй бий болоогүй. Якобын үхлийг оролцуулаад хавчлага зовлонтой тулгарч байсныг 12-р бүлэгт бичжээ. Мөн Пэтрийг шоронд хорьсон тухай 12-р бүлэгт өгүүлдэг.

Гэвч энэ бүх зөрчил тэмцэл эсэргүүцэл бэрхшээл нь Сайн мэдээг гэрчлэх явдалд огт саад болж чадаагүй. Ариун Сүнс Есүст итгэгчдийн авралын зарын ажил болон дагалдагч бэлтгэх үйлсийг ивээсээр л байлаа. Яс үндсээр ялгаварлан гадуурхах явдал болон хавчлага зовлонг даван туулахад Ариун Сүнс туслав. Түүгээр ч барахгүй Пэтрийг шоронгоос гайхалтай аргаар чөлөөлдөг. Замд нь ямар ч саад бэрхшээл тулгарсан Сайн мэдээ урагш ахисаар л байлаа.

## Кипр арал, Фрууг, Галат аймаг

Үйл явдал номын 13-ийн 1-ээс 15-р бүлгийн 35-д Луух Сайн мэдээ тарсан дөрөвдөхь гол хэсгээ өгүүлдэг. Энэ бол Сайн мэдээ Кипр арал, Фрууг, Галат аймагт тарсан тухай хэсэг юм. Энд Сайн мэдээ Иерусалим хот, Иудей Шомрон аймгаас цааш Бага Азийн хойгийн өмнөд хэсэгт хүрч байгаа тухай өгүүлдэг. Үйл явдал номын энэ хэсгийг хоёр хувааж болно. Эхнийх нь 13-р бүлгийн 1-ээс 14-р бүлгийн 28-д гарах Пуулийн эхний аялалын тухай хэсэг бол, хоёрдахь нь 15-р бүлгийн 1-ээс 35-д гарах Иерусалим хотод хуралдсан зөвлөлийн хурлын тухай хэсэг юм.

Луух энэ удаа ч гэсэн арга барилаа хадгалж, энд дотоод өсөлт болон зөрчлийн загвараа тусган харуулдаг. Тэрбээр дотоод өсөлтийг 14-р бүлэгт Галатын сүмүүдийг Пууль хэрхэн бэхжүүлж байгаагаар, 15-р бүлэгт Есүст итгэсэн Иудей бус хүмүүст хөвч хөндөх ёслол хийхгүй байх тухай Иерусалимийн зөвлөлийн шийдвэр зэргээр үзүүлдэг.

Луух энэ хэсэгт мөн дотоод зөрчлийн тухай дурдсан байдаг. Ялангуяа Иудей бус итгэгчдэд тулгарсан бодит бэрхшээлийн тухай өгүүлдэг. Хөвч хөндөх ёс болон Иудейчүүдийн уламжлалт хатуу хоолны дэглэм зэрэг асуудлаас болж Иудей болон Иудей бус итгэгчдийн дунд гарсан зөрчлийг 15-р бүлэгт дурджээ.

Луух 14-р бүлэгт Пуулийн авралын зарын эхний аялалаар маш олон хүн Есүст итгэсэн гэх зэрэг нэлээд хэдэн асуудлыг хөндөж гадаад өсөлт болон эсэргүүцлийн талаар дурдсан байдаг. Өмнөхийн адил энэ өсөлт нь маш хүчтэй эсэргүүцлийг дагуулав. Жишээ нь, Пууль Барнаб хоёрыг ялангуяа Луустар, Ихонион болон Антиох хотод Иудей үл итгэгчид хүлээн авахаас дахин дахин татгалзсан тухай 14-р бүлэгт өгүүлдэг. Тэглээ ч гэсэн Ариун Сүнс Христэд итгэгчдийн бүлгийг урагш ахиулсаар, тэд замдаа тохиолдох бэрхшээл саад бүрийг даван туулсаар байв. Хэн ч зогсоож үл чадах Сайн мэдээ урагшилсаар Ертөнцийн Эзэний зорилгыг биелүүлсээр байв.

## Бага Ази, Македони, Ахай аймаг

Үйл явдал номын тав дахь том хэсэг бол Сайн мэдээ Ромын Эзэнт улсын Бага Ази, Македони, Ахай аймагт тарж байгааг өгүүлсэн 15-р бүлгийн 36-аас 21-р бүлгийн 16 хүртэлх ишлэл юм. Энэ хэсэг нь Бага Азийн хойгийн өмнөд нутгаар явсан Пуулийн авралын зарын хоёр болон гуравдахь аялалд гол анхаарлаа хандуулдаг. Пууль энэ нутагт өмнө нь ирж байсан ч цааш үргэлжлүүлэн явсаар Бага Азийн хойгийн өмнө хэсэгт хүрч, улмаар Эгийн тэнгисийг гаталж одоогийн Грек улсын нутаг болох Македони, Ахай аймгийн олон хотоор аялдаг.

Пуулийн авралын зарын хоёрдахь аялалыг Үйл явдал номын 15-р бүлгийн 36-аас 18-р бүлгийн 22-т, харин гуравдахь аялалыг нь 18-р бүлгийн 23-аас 21-р бүлгийн 16-д бичсэн байна. Бидэнд тун танил болсон нөгөө загварыг маань эдгээр бүлэгт дотоод өсөлт ба зөрчлийн хоорондын харилцааг онцолж байгаагаар харуулсан байна. Бид эдгээр бүлгээс дотоод өсөлтэй холбоотой олон жишээг харж болно. Жишээ нь 18-р бүлэгт Присхил, Ахуул хоёр Аполд заавар зөвлөгөө өгсөн тухай, 19-р бүлэгт Пууль Эфэс хотын синагогуудад болон Туран гэдэг хүний

танхимд өргөтгөсөн цуврал сургалт явуулсан талаар өгүүлдэг.

Мэдээж энэ дотоод өсөлт нь маш их зөрчил тэмцэл дагуулав. Жишээ нь, Пууль Барнаб хоёр Маархаас болж маргалдаж улмаар салж явцгаасан тухай 15-р бүлэгт, Луух Есүст итгэгчдийг ёрын муу хүсэлтэй ахлагч нараас сэрэмжлүүлсэн тухай 20-р бүлэгт тус тус өгүүлэв.

Бид энд бас л гадаад өсөлт болон эсэргүүцлийн тухай уншдаг. Бид гадаад өсөлтийн жишээг 15-аас 21-р бүлэгт Пуулийн авралын зарын хоёр болон гуравдахь аялалын үеэр маш олон хүн Есүст итгэж, тэрбээр итгэгчдийн олон бүлэг байгуулж байгаагаас хардаг билээ. Мөн бид гадаад эсэргүүцлийг жишээг 17, 21-р бүлэгт уурласан олон хүн Пуулийг алах гэж оролдож байгаагаас, 17, 20-р бүлэгт Иудейн шашиныг хатуу баримтлагчид Пуулийг нэг хотоос нөгөө хот уруу мөшгин мөрдөж, ард олныг түүний эсрэг турхиран босгосон зэргээс хардаг. Дахиад л Луух Сайн мэдээ дэлхий даяар үр дүнтэй тархаж байгааг харуулав. Дотоод зөрчил ба гадаад эсэргүүцэл нь үргэлжийн бэрхшээл учруулж байсан ч Ариун Сүнсний эрх мэдэл олгосон Сайн мэдээг гэрчлэх ажлын өсөлтийг зогсоож чадаагүй юм.

## Ромд

Сайн мэдээ хэрхэн түгсэн тухай Луухын бичсэн хамгийн сүүлчийн томоохон хэсэг нь Ром хотод төвлөрдөг бөгөөд 1-р бүлгийн 17-оос 28-р бүлгийн 31-ийг хамардаг. Энэ хэсэг Пуулийн Иерусалим хотоос эхэлсэн аялал, тэгээд түүнийг хэрхэн баривчилж хорьсон болон Ром хот уруу хүргэж байгаад гол анхаарлаа хандуулжээ. Үүнийг ерөнхийд нь багцаалаад дөрөв хувааж болно. Эхнийх нь 21-р бүлгийн 17-оос 23-р бүлгийн 11-ийг хамарсан Пуулийн Иеруалим хотод хэлсэн сүүлчийн гэрчлэл, удаах нь 23-р бүлгийн 12-оос 26-р бүлгийн 32-т буй Пуулийн шоронд орсон тухай хэсэг бол, мөн түүний Ром хүрсэн хүнд хэцүү аялалыг 27-р бүлгийн 1-ээс 28-р бүлгийн 14-т үзүүлсэн. Тэгээд эцэст нь 28-р бүлгийн 15-аас 31-д буй Ром хотод хийсэн Пуулийн гэрчлэл юм.

Эдгээр бүлэгт бидний сайн мэдэх нөгөө дотоод өсөлт ба зөрчил гэсэн загвар бас л байна. Бид дотоод өсөлтийн хэдэн нотолгоог олж хардаг. Жишээлбэл, 21-р бүлэгт Иудей бус олон хүн Их Эзэн Есүст итгэснийг сонсоод Иудей итгэгчид баярлан хөөрсөн тухай, 22-р бүлэгт Сайн мэдээг тараахын тулд Пууль болон бусад хүн зовлон эдэлж түүгээр ч барахгүй амь насаа ч зориулахад бэлэн байгаа тухай тус тус өгүүлсэн байдаг.

Бид бас дотоод өсөлт нь зөрчил дагуулж байгааг харж болно. Жишээ нь, Пууль Иудей итгэгчдэд өв уламжлалаа орхих тухай сургаал заасан гэдэг цуурхал, мөн түүнийг Иерусалимын сүмд очсоноос болж дараагийн зөрчил үүссэн тухай 21-р бүлэгт тус тус өгүүлжээ.

Бид бас гадаад өсөлт болон эсэргүүцлийн загвар хэрэгжиж байгааг хардаг. Энэ үед Христэд итгэгчид гадаад өсөлтийн хувьд том алхам хийсэн гэж Луух бичжээ. Жишээ нь, Пууль Христийн тухай сайн мэдээг дээд тушаалын олон хүнд танилцуулж чадсаныг 23, 24, 25, 26, 28-р бүлэгт бичсэн бол, түүнийг Ром хотод ямар ч саадгүй Сайн мэдээг тунхаглаж чадсаныг 28-р бүлэгт тус тус өгүүлжээ. Гэхдээ Луух бас энэ өсөлттэй хамт маш хүчтэй эсэргүүцэл бий болсныг Пууль баривчлагдаж, улмаар түүнийг Ромын эрх баригчид дөрвөн жил шоронд хорихоор

болсоныг 24-р бүлэгт, түүнийг Ромд хорионд байлгасан тухай 28-р бүлэгт бичсэн байдаг.

Дээрх гол хэсэг бүр Сайн мэдээг найдвартай гэрчилж байсан гэрчлэл бүхэн бүтэлгүйтэж байгаагүй гэдгийг нотлож байна. Ариун Сүнс Сайн мэдээг Иерусалимаас Ромын Эзэнт улсын нийслэл хотод хүргэх эрх мэдлийг Есүст итгэгчдэд олгов. Хэдийгээр Есүст итгэгчид дотроо болон гадна талдаа бэрхшээл саадтай тулгарч байсан боловч юунд ч үл торох Сайн мэдээ нь Ертөнцийн Эзэний хаант улсыг энэ дэлхийн өнцөг булан бүрт түгээж байхдаа Христэд итгэгчдийг оюун санаагаар нь хүчирхэг болгож тооны хувьд өсгөж байжээ.

## ОРЧИН ҮЕИЙН ХЭРЭГЖҮҮЛЭЛТ

Ийнхүү бид Үйл явдал номын “Уран яруу өгүүлэх арга барил” болон “Агуулга”-ыг үзсэн тул одоо “Орчин үеийн хэрэгжүүлэлт” хэмээх гуравдахь гол сэдвээ үзэцгээе. Бид өнөө үед Үйл явдал номонд бичсэн үнэнийг хэрэгжүүлэхийн тулд юуг голлон анхаарах ёстой вэ? Энэ сэдвийг судлахын тулд бид эхлээд Үйл явдал номын утга зохиолын шинж чанар болон үүний зарим нэг онцлог байдалд гол анхаарлаа хандуулна. Хоёрдугаарт, бид энэ номыг орчин үед хэрэгжүүлэхэд маань нөлөөлж буй 1-р зуун болон өнөө үеийн хооронд үл үргэлжилэх зарим нэг зүйлийн тухай ярилцана. Гуравдугаарт, бид энэ номын эх утгыг өнөөгийн бидний амьдралтай холбоход тус болох 1-р зуун болон орчин үеийн хооронд үргэлжилэх зарим нэг чухал зүйлийг батлах болно. За бүгдээрээ Үйл явдал номын утга зохиолын шинж чанарыг үзэж эхэлцгээе.

### УТГА ЗОХИОЛЫН ШИНЖ ЧАНАР

Утга зохиолын өөр өөр төрлүүд нь аливаа санааг янз бүрийн аргаар дамжуулдаг билээ. Жишээ нь, бид Библиэс янз бүрийн төрлийг олж хардаг. Тэнд түүхэн хүүрнэл, яруу найраг, илтгэл, сургамжит үлгэр, сургаал үгс, хууль гэх мэтийн утга зохиолын олон төрөл бий. Эдгээр утга зохиолын төрөл бүр янз бүрийн аргаар санаагаа дамжуулдаг. Хэрэв бид Үйл явдал номыг хариуцлагатай сайн ойлгохыг хүсэж байгаа бол энэ нь утга зохиолын ямар төрлөөр бичигдсэн болон иймэрхүү төрөл нь утга санааг хэрхэн дамжуулдагийг мэдэх шаардлагатай байдаг.

Бид Үйл явдал номын тухай утга зохиолынх нь талаас олон зүйлийг хэлж чадах ч, цаг хугацааны боломжоосоо шалтгаалаад үүний гурван чухал онцлог шинжийг авч үзэх болно. Нэгдүгээрт, Луух юуны тухай бичихээ сонгосон байна. Хоёрдугаарт, тэрбээр Үйл явдал номыг хэсэг хэсгээс бүрдэх хэлбэрээр төлөвлөсөн байна. Харин гуравдугаарт, маш олон сургаалиа далд хэлбэрээр заажээ. Эхлээд бүгдээрээ Үйл явдал номын материалыг сонгосон талаар үзэцгээе.

### Сонгосон

Түүхч бүр материалаа сонгох хэрэгтэй байдаг. Ямар ч хүний хувьд дэлгэрэнгүй мэдээлсэн ч гэсэн дэндүү ахадмаар олон баримт, хүмүүс, үйл явдал болж байдаг билээ. Үйл явдал номонд гарч байгаа зүйлс нь Есүсийг тэнгэрт одоноос эхлээд Пуулийг Ром хотод шоронд байх хүртэл 30-аас 40 жилийг хамардаг. Энэ хугацаанд Христэд итгэгчдийн дунд тоолж барамгүй маш олон гайхалтай чухал үйл явдал болж өнгөрсөн билээ. Гэсэн хэдий ч Луух энэ бүгдийг 28 богино бүлэгт багтаан бичсэн юм. Тэгэхлээр тэрбээр хэлэхийг хүссэн зүйлсийнхээ өчүүхэн хэсгийг л мэдээлсэн байна. Тэгвэл Луух ямар үйл явдлыг оруулахаа хэрхэн тодорхойлж байв? Юуг нь оруулахгүй хасахаа хэрхэн шийдэв ээ? Төлөөлөгчдөөрөө дамжуулан хийсэн Есүсийн ажлыг ойлгож, улмаар тэдний заасан зарим нэг гол сургаалыг уншигчид нь хүлээн авахад ятгахын тулд Луух тэр бүх жижиг сажиг хэсгийг сонгохдоо Ариун Сүнсээр удирдуулсан юм.

Тийм учраас бид өнөө үед Үйл явдал номыг амьдралд хэрэгжүүлэх арга замыг олохын тулд хоёр зүйлийг хийх хэрэгтэй. Нэг талаар Христэд итгэгчдийн энэ үеийн тухай

бидний мэдэхийг хүссэн бүх зүйлийг Луух бичсэн гэдэг алдаатай үзлээс зайлсхийх хэрэгтэй. Тэрбээр маш олон асуултын хариултыг өгөөгүй учраас бид өнөө үеийнхээ асуудал бүрийн хариултыг Үйл явдал номноос хайхгүй байх нь чухал.

Нөгөө талаар бид Үйл явдал номын хэсэг бүр нь Луухын хоёр талт зорилгыг биелүүлэхэд туслах үүрэгтэй байсан гэдгийг санаж байх хэрэгтэй. Тийм учраас бид Үйл явдал номын бүх хэсгийг уншиж байхдаа энэ нь Луухын зорилгыг биелүүлэхэд хэрхэж тусалж байна вэ гэдгийг харгалзан үзэж байх хэрэгтэй. Бид, “Энэ нь надад эхэн үеийн итгэгчдийн тухай юу зааж байна вэ? Намайг ямар онол сургаалыг хүлээн авахыг маань дэмжиж байна вэ?” гэх мэхийн асуултыг өөрсдөөсөө байнга асууж байх хэрэгтэй

## Хэсэг хэсгээс бүрдсэн

Энэ номын материалыг сонгосноос гадна хэсэг хэсгээс бүрдүүлсэн шинж байдаг. Өөрөөр хэлбэл Үйл явдал ном бол ар араасаа дараалан орсон олон жижиг түүх болон тэмдэглэлийн цуглуулга юм. Бид Үйл явдал номыг уншиж байхдаа үүний бие даасан хүүрнэл бүр нь Луухын хэлэх гэсэн ерөнхий санаа болон баримталж байсан стратегийн нэг хэсэг гэж үзэх нь чухал. Хэсэг бүр нь Христийн тунхагласан Ертөнцийн Эзэний хаант улсын тухай сайн мэдээний талаар Тёфилд заах гэсэн түүний ажилд тус дэм болж байна. Тиймээс энэ том зураглал нь Үйл явдал номноос бидний уншиж буй хэсэг бүрийн түүхэн орчин нөхцөл болон хам сэдвийн үүрэг гүйцэтгэх ёстой.

Гэхдээ хэсэг бүр нь бусдаасаа ялгаатай байдаг. Христэд итгэгчид Их Эзэний тунхагласан Сайн мэдээгээр дамжуулан Ертөнцийн Эзэний хаант улсыг байгуулах ажлаа хэрхэн үргэлжлүүлэх талаар хэсэг бүр жижиг санаа гаргаж нарийвчлан заадаг. Өөрөөр хэлбэл бид уг номыг уншиж байхдаа Луухын ерөнхий зорилго нь түүний хэлсэн салангид санаануудыг бүрхэгдүүлэхийг зөвшөөрч болохгүй гэсэн үг юм. Бид том болон жижиг зураглалд анхаарлаа хандуулж, хэсэг бүр хэрхэн

ерөнхий зорилгод хувь нэмэр оруулж байгааг ойлгох хэрэгтэй. Мөн хэсэг бүр нь тэр зорилгын нарийн ширийн зүйлийг тодорхойлоход хэрхэн тусалж байгааг мэдэх хэрэгтэй. Үйл явдал номын хүүрнэл хэлбэр нь сонгосон, хэсэг хэсгээс бүрдсэнээс гадна утга зохиолын төрлийн хувьд ихэнх сургаалиа далд хэлбэрээр заасан шинжтэй байдаг.

## Далд хэлбэрээр заасан

Ерөнхийдөө бол Шинэ Гэрээнд хүүрнэсэн хэлбэрийн яриа, баталсан хэлбэрийн яриа гэсэн утга зохиолын хоёр гол төрөл байдаг. Баталсан хэлбэрийн яриа гэдэг нь тухайн номын гол дүр эсвэл зохиогч уншигчиддаа шууд хандаж ярих гэх мэтийн харилцан яриаг илэрхийлсэн утга зохиолын төрөл юм. Жишээлбэл Шинэ Гэрээний захидалууд нь гол төлөв Пууль мэтийн зохиогч нь захидалыг хүлээн авсан хүмүүст шууд хандан ярьж буй баталсан хэлбэрийн ярианаас бүрддэг. Мэдээж зарим захидалд жижиг сажиг хүүрнэл яриа, түүгээр ч барахгүй магтаал дуу эсвэл сургаал үгс байдаг. Гэхдээ ихэвчилэн баталсан хэлбэрийн ярианаас бүрддэг. Баталсан хэлбэрийн яриа нь сургаалийг шууд бөгөөд тодорхой дамжуулдаг гэдгийг бид энд онцолж хэлэх нь зүйтэй болов уу. Пууль уншигчиддаа ямар нэгэн зүйлийн талаар бодох эсвэл хийхийг захидалдаа бичихдээ хүсэж байгаа бүхнээ шууд хэлдэг байсан.

Гэхдээ хүүрнэсэн хэлбэрийн яриа бол Сайн мэдээний дөрвөн ном, мөн хамгийн чухал нь Үйл явдал номонд буй эдгээр хичээлийн утга зохиолын голлох төрөл болдог юм. Хүүрнэсэн хэлбэрийн яриа нь түүхийг өгүүлж, аливаа сургаалийг арай шууд бус аргаар хүргэдэг байна. Баталсан хэлбэрийн яриа ч гэсэн эдгээр номонд, ялангуяа зарим нэг хүний ярианд харагддаг. Гэхдээ Сайн мэдээний номууд болон Үйл явдал номонд хүүрнэсэн хэлбэр яриа зонхилдог. Ил тод заахыг хичээдэг баталсан хэлбэрийн яриаг бодвол хүүрнэсэн хэлбэрийн яриа нь уншигчиддаа ухаж ойлгох боломж олгохын тулд далд утгаар заадаг. Хүүрнэл нь уншигчдад шууд заавраар бус илүү нарийн аргаар нөлөөлдөг. Уншигчид нь тухайн номонд гарч буй хүмүүсийн үг яриа, үзэл бодол, үйлдлээс сургамж авч тэр бүхнээсээ Ертөнцийн Эзэнд таалагдах хэсгийг нь авч, Түүний хүслийн эсрэг зүйлээс цэрвэж байхыг сурч авах бүтэцтэйгээр хүүрнэлүүдийг хийсэн байдаг.

Үүнийг ингэж үзэж болно. Үйл явдал ном шиг хүүрнэл зохиолуудад зөвхөн баримт л дурдсан юм шиг санагддаг. “Ийм ч юм боллоо, тийм ч юм боллоо. Тэгээд ийм юм боллоо” гэх мэт. Өнгөц харахад энэ нь зүгээр л үйл явдлыг мэдээлж байгаа мэт байдаг. Луух үе үе өөрийн бичсэн түүхийнхээ ач холбогдлыг илэрхий бичсэн байгааг бид хардаг. Гэхдээ ихэнх хэсэгт тэрбээр үйл явдал эсвэл баримтын талаар үл ялиг тайлбар хийдэг. Заримдаа бүр тайлбар огт бичдэггүй. Гэвч бодит байдал бол түүний хүүрнэлүүд нь зөвхөн үйл явдлыг мэдээлдэггүй. Түүнд бусдад сургамжлан заах бодол байсан. Тэрбээр хүүрнэлүүддээ санаа бодлоо далд хэлбэрээр дамжуулсан юм.

Би энэ санааг та бүхэнд амьдралдаа тохиолдсон нэг үйл явдлаар жишээ болгон үзүүлэе. Охин маань жаахан байхад бид түүнд оройн хоолны өмнө шоколад идэхийг хориглосон байв. Гэтэл нэг орой тэр маань урууландаа шоколадтай оройн хоолонд ирэв. Би түүнээс шоколад идсэн эсэхийг асуутал тэр маань идээгүй царай

гаргаад, “Аав аа! Би ямар ч шоколад идээгүй” гэдэг юм байна.

Эцэг хүний хувьд би энэ асуудлыг хоёр арга замаар шийдвэрлэж болох байв. Би энэ асуудлыг баталсан хэлбэрийн яриагаар шууд бөгөөд тодорхой ярьж болно. Тэгээд түүнд, “Чи үнэнээ хэлэхгүй байна гэнэ ээ! Нүүрэн дээр чинь шоколадны үлдэгдэл байгааг харж байна. Чи ч асуудалд орлоо доо” гэж хэлж болно. Эсвэл би хүүрнэх хэлбэрийн яриаг сонгож, арай шууд бус, далд утгаар ярьж болно. Би охиноо өвөр дээрээ суулгаад, “Охин минь, би чамд нэг үлгэр ярьж өгье. Эрт дээр үед нэг жаахан охин байжээ. Эцэг эх нь түүнд хамгийн гоё хувцастайгаа гадаа битгий тоглоорой гэж хэлсэн байна. Гэтэл энэ охин гоё хувцастайгаа тоглоод хувцсаа муухай болгочихжээ. Энэ охины хийсэн зүйлийн талаар чи юу гэж бодож байна?” гэж хэлж болох юм.

Иймэрхүү уран яруу аргыг хэрэглэсэн хүүрнэх хэлбэр нь ихэвчлэн далд утгаар өгүүлдэг. Энэ нь уг охинд, “Энэ хүүхэд эцэг эхийнхээ үгэнд ороогүй муухай охин байна шүү” гэсэн бодол төрүүлж байна. Иймэрхүү санаа бодлыг шууд бус хэлбэрээр дамжуулж чаддаг нь хүүрнэн өгүүлэх хэлбэрийн сайхан бөгөөд хүчтэй тал нь юм. Хэрэв энэ нь хангалттай байж чадвал хүүрнэл нь сонсогчийг тухайн түүхийн нөхцөл байдал дунд оруулж чаддаг. Сонсогч уг түүхийг эсэргүүцэх бус өөрөө хувьчлан оролцдог байна. Ингэснээр тэрбээр аливаа заасан бүхнийг сурах боломжтой болдог аж.

Барагцаалбал Үйл явдал номын 70% нь хүүрнэл яриа байдаг. Уг номын ихэнх хэсэгт Луух уншигчиддаа, “Би та бүхэнд анхны итгэгчдийн дунд Ертөнцийн Эзэний хийсэн ажлын тухай ярьж өгье” гэж хэлж байгаа юм шиг байдаг. Мэдээж тэдэнд ярьсан түүх бол туйлын үнэн билээ. Тэрбээр тэднийг баримтат түүхэнд урьж байна. Гэхдээ тэрбээр уншигчид нь түүний бичсэн баримтаас өөрсдөө дүгнэлт хийхийг хүссэн учраас үүнийг түүх хэлбэрээр танилцуулж байна. Тиймээс бид Үйл явдал номыг уншиж байхдаа иймэрхүү далд утгатай сургаалийг хайж үзэх нь чухал байдаг.

Библийн ямар ч хүүрнэл хэсгийг дүгнэж амьдралдаа хэрэгжүүлэх хамгийн сайн арга бол тухайн болж буй үйлдэлд Ертөнцийн Эзэн хэрхэн хандаж буйг харах явдал юм. Түүний үг болон үйлдэл нь ямар ч алдаа мадаггүй байдаг нь хамгийн чухал билээ. Тэгэхлээр бид Үйл явдал номыг уншиж байхдаа Ертөнцийн Эзэний хүлээн зөвшөөрч ивээж байгаа бүхнийг, мөн Түүний зөвшөөрөхгүй харааж байгаа бүхнийг үргэлж анхаарч байх хэрэгтэй. Ертөнцийн Эзэний ивээж байгаа бүхэн сайн, харааж байгаа бүхэн ёрын муу байх ёстой. Энэ номыг уншиж байхдаа Ертөнцийн Эзэнд таалагддаг итгэл үнэмшил, хандлага, зан авирыг дууриаж, Түүнийг эсэргүүцдэг бүхнээс зайлсхийхийг хичээх хэрэгтэй.

Үүн дээр нэмээд Луух эхэн үеийн сүмийн алдартай удирдагчдын үзэл бодолд тун нухацтай хандаж байсан учраас бид түүний бичсэн жишээнүүдийг хянуур ажигласнаар бас далд утгатай сургаалын утгыг мэдэж чадна. Төлөөлөгчид, зөнчид болон сүмийн бусад хүндэт удирдагчид гэх мэтийн найдаж болохуйц хүмүүс ямар нэгэн зүйл хэлж эсвэл хийхэд нь бид тэдэнд уриалагхан ханддаг. Учир нь тэдний үйлдэл нь зөв, гэрчлэл нь үнэн байдаг билээ. Тиймээс бид тэдний ийм дуудлагад зүрх сэтгэлээсээ хариулж, зан авир үзэл бодлыг нь үлгэрлэн дууриах хэрэгтэй.

Энэ бүхний эсрэг байгаа зүйл бас үнэнийг агуулдаг. Үйл явдал номонд Төлөөлөгчид эсвэл Есүст итгэгчдийн буруушааж байгаа хүмүүсийг хараад бид “Тэр

хүмүүсийн үйлдэл бол буруу юм байна” гэсэн дүгнэлт гаргаад тэдний үлгэр жишээг дагахгүй байх хэрэгтэй. Эдгээр Үйл явдал номонд Луухын хэлэх гэсэн цорын ганц төрлийн далд утга санаа байгаагүй юм. Харин энэ бүхэн орчин үеийн уншигчид библийн хүүрнэл хэсгүүдээс хэрхэн зөв дүгнэлт гаргаж сурахад нэлээд баттай суурь болж өгдэг.

Ийнхүү бид Үйл явдал номын утга зохиолын шинж чанарыг ойлгосон тул одоо уг номыг амьдралд хэрэгжүүлэхэд маань нөлөөлж болох нэгдүгээр зуунаас өнөө үед үргэлжлүүлж болохгүй зүйлсийн талаар мэдэж авах хэрэгтэй.

## ҮЛ ҮРГЭЛЖИЛЭХ ЗҮЙЛС

Хэдийгээр Библийг бидний төлөө бичсэн ч гэсэн бидэнд хандан шууд бичээгүй юм гэдгийг бид үргэлж санаж байх хэрэгтэй. Анхны уншигчид нь МЭ-ний 1-р зууны үед амьдарч байсан хүмүүс болон Тёфиль нар байсан гэдгийг бид тодорхой мэднэ. Зарим талаараа бид Луухын бичсэн номыг тэдэнтэй хамт уншиж байгаа юм шиг байдаг. Бид тэдэнд хандаж Луухын хэлж байгаа бүхнийг сэм чагнаж байгаад түүний бидэнд хандан хэлж байгаад үгийг төдийлөн сайн сонсдоггүй. Тэгэхлээр бид Үйл явдал номын зарим нэг сургаал нь бидэнд Тёфиль болон Луухын бусад уншигчдаас огт өөрөөр хэрэгждэг гэдгийг хүлээн зөвшөөрөх хэрэгтэй Хэрэв бид иймэрхүү ялгааг харгалзан үзэхгүйгээр Бичээсээс харсан бүхний зүгээр л давтахыг хүсвэл Ертөнцийн Эзэний Үгийг ихэвчлэн маш хөнөөлтэй байдлаар буруу хэрэглэдэг.

Бид Луухын үе ба өнөөгийн бидний үеийн хооронд үл үргэлжилэх зүйлсийг хоёр байдлаар хураангуйлан үзэх болно. Нэгдүгээрт, бид тэд нарынхаас огт өөр цаг үед амьдарч байна. Хоёрдугаарт, нэгдүгээр зуунаас хойш дэлхий ертөнц маань огт өөр болсон. Бид Луухыг энэ номоо зориулж бичсэн хүмүүсийн амьдарч байснаас огт өөр орчин, нөхцөл байдал дунд амьдарч байна. Бид эхлээд Үйл явдал номыг анх хүлээж авсан хүмүүсээс огт өөр цаг үед амьдарч байна гэсэн баримтыг судлана.

## Өөр цаг үе

Жишээлбэл Үйл явдал ном нь 1-р зууны үед Христийн эрх мэдэлтэй гэрч болж байсан Төлөөлөгчид дээр анхаарлаа хандуулж байсныг санаж байх нь тун чухал байдаг. Есүсийн төлөөлөгчдөөр дамжуулан Ертөнцийн Эзэний хийсэн олон ажил нь авралын түүхийн тухайн цаг үе болон газар нутагт онцгой байсан юм. Эдгээр нь шинийг сэдсэн, үндэс суурийг авсан үйл хэрэг байсан бөгөөд дахин хэзээ ч давтагдахгүй билээ. Ганцхан жишээ авъя л даа. Зөвхөн төлөөлөгчдийн оршин байсан нь хосгүй явдал байв. Бид дараагийн хичээлээр Есүсийн өөр төлөөлөгч гэж дахиж хэзээ ч гарч ирээгүй талаар үзнэ. Тухайн хүн дахин амилсан Их Эзэнийг харсан байх ёстой гэдэг нь Есүсийн төлөөлөгч болох хүнд тавигдах нэг шаардлага байлаа. Өөр нэг шаардлага нь тухайн хүнийг Есүсийн төлөөлөгчийн албан тушаалд Ертөнцийн Эзэн өөрөө томилох ёстой байв. Хэдийгээр Үйл явдал



ном бидэнд сүмийн удирдагчдаа хүндэлж тэдэнд захирагдах тухай заадаг гэж хэлж болох ч, өнөөгийн бидний дунд Есүсийн амьд төлөөлөгч гэж байхгүй билээ. Бид Шинэ Гэрээнд буй тэдний тухай өгүүлсэн бичмэл гэрчлэлүүдэд л захирагдаж байхад болно.

Харамсалтай нь Христэд итгэгчдийн олон бүлэг Үйл явдал номыг үе бүрд нарийвчлан дагах итгэгчдийн амьдралын загвар мэт үздэг. Жишээ нь Үйл явдал номын 2-р бүлгийн 1-ээс 4-д Пэнтээхөст баярын өдөр Ариун Сүнс маш сэтгэл хөдөлгөм гайхалтай байдлаар бууж ирж, улмаар Түүнийг хүлээн авсан хүмүүс харь орны хэл яриа, аялгаар сайн мэдээг тунхагласан тухай өгүүлдэг. Энэ бол Төлөөлөгчид болон эхэн үеийн зарим итгэгчдэд Христийн ажил үйлчлэлийг хийх эрх мэдэл олгохын тулд Ариун Сүнс анх удаа ирж буй онцгой явдал байв. Үүнтэй төстэй явдал энэ номонд зөвхөн Төлөөлөгчдийн ажил үйлийн шууд үр дүн болж хэд хэдэн удаа дахин давтагддаг. Ариун Сүнсийг хүлээн авсан хүн бүрийн зан чанар нь өөрчлөгдөж, Христийн тухай амжилттай гэрчилж байсан баримт Үйл явдал номонд байнга гардаг. Ариун Сүнсний тодорхой илэрхийлэлт ямар үед байгаад, харин ямар үед байхгүй байх талаар Үйл явдал номонд тогтмол өгүүлээд байдаггүй. Гэтэл Христийн зарим сүм өнөө үед ч гэсэн хувь хүнд Ариун Сүнс ирсэн үед тэр хүн үргэлж янз бүрийн үл мэдэх хэл яриагаар Сайн мэдээг тунхаглах ёстой хэмээн шахаж шаарддаг. Сайн санаат Христэд итгэгчид 1-р зуун болон өнөө үеийн хоорондын үл үргэлжилэх зүйлсийг анхаарч авч үзэхгүй тохиолдолд тэд Үйл явдал номын сургаалийг гол төлөв буруу хэрэгжүүлдэг байна.

## Өөр нөхцөл байдал

Бид Үйл явдал номын анхны уншигчдаас өөр цаг үед амьдарч байгаагаас гадна өөр соёл, хувь хүнийхээ хувьд өөр орчинд амьдарч өөр нөхцөл байдалд байгаа билээ. Үйл явдал номонд гарч байгаа бүхэн 1-р зууны үеийн түүхэн нөхцөл байдалд дунд болж өнгөрсөн. Луухын тэмдэглэлийн олон хэсэг нь эдгээр түүхэн болон соёлын нөхцөл байдал дунд бий болсон билээ.

Харамсалтай нь Үйл явдал номноос сургаал заахдаа үүнийг олон удаа үл тоомсорлодог. Христийн олон сүм цуглаан зуун зууны турш 1-р зуун үеийн сүмд дадал болсон соёл уруу эргэж буцаж байлаа. Жишээ нь, Үйл явдал номын 5-р бүлгийн 42-оос бид Христэд итгэгчид гэрт цугладаг байсан тухай уншдаг. Христэд итгэгч зарим хүн үүнийг үндэс болгоод өнөөгийн сүм цуглааныг байшинд биш гэр орноороо цуглах ёстой гэж шаарддаг. Мөн Үйл явдал номын 6-ийн 1-д Иерусалим хотын сүм бэлбэсэн эмэгтэйчүүдэд хоол хүнс өгдөг байсан тухай уншдаг. Гэтэл өнөө үед Христэд итгэгч зарим хүн сүм бүр үйлчлэлийн нэг хэсэг болгож бэлбэсэн эмэгтэйчүүдэд хоол хүнс өгөх ёстой гэж зүтгэдэг. Мэдээж өнөө үед Есүст итгэгчид гэрт цуглаж эсвэл бэлбэсэн эмэгтэйчүүдэд хоол хүнс өгөхөд ямар ч буруу зүйл байхгүй л дээ. Гэхдээ бид иймэрхүү ажил хэрэг нь 1-р зууны үеийн сүм цуглаануудад тулгарсан нөхцөл байдлаас болж бий болсон гэдгийг ухаарах хэрэгтэй. Жишээ нь, хавчлага зовлон нь Христэд итгэгчдийг гэр орноороо цуглахаас өөр аргагүй байдалд оруулсан юм. Харин хавчлага зовлон бага байдаг эсвэл огт байдаггүй улс оронд Христэд итгэгчид гэрт цуглах ямар ч шаардлага

байхгүй. Өөрөөр хэлбэл, бидний нөхцөл байдал хэдий чинээ тэд нарынхтай адил байна библийн дээрх зарчмыг хэрэгжүүлэх нь төдий чиний зүй ёсны байх болно. Харин бидний нөхцөл байдал огт өөр байвал бид библийн дээрх зарчмыг өөрөөр хэрэгжүүлэх үүрэгтэй байж болох юм.

Үнэнийг хэлэхэд бид Үйл явдал номонд хүртэл дээрх зарчмыг өөрөөр хэрэгжүүлж байгааг олж хардаг. Жишээлбэл, Үйл явдал 2-р бүлгийн 44-ээс 45-д Иерусалим хотын Есүст итгэгчид бүх зүйлээ хуваан эдлэж байсан тухай Луух дүрслэн бичсэн байдаг. Гэхдээ Төлөөлөгч Пуулийн байгуулсан Христэд итгэгчдийн олон бүлэг тухайн хотын баян иргэд эсвэл захирагч нарын гэрт цуглаж байсан боловч баян ядуугүй бүх зүйлээ хуваан хэрэглэж эсвэл ингэж хэрэглээгүй гээд бусдыг шүүмжилсэн хэсгийг бид олж хардаггүй билээ. Тэгэхлээр Христэд итгэгчид бүр анхнаасаа л библийн ижил төстэй зарчмуудыг одоогийн нөхцөл байдалтайгаа нийцүүлэн хэрэгжүүлэх ёстой гэдгийг хүлээн зөвшөөрсөн байна. Тиймээс бид өнгөцхөн хуулбарлан дуурайж байгаагаа библийн зарчмуудыг хариуцлагатай хэрэгжүүлэх явдлыг орлуулж болно гэж хэзээ ч үзэж болохгүй.

Ийнхүү бид Үйл явдал номын утга зохиолын шинж чанарыг тодорхойлж, Луухын амьдарч байсан үеэс өнөөгийн бидний хооронд үл үргэлжлэх зүйлсийг ерөнхийд нь багцалсан тул одоо 1-р зуунаас өнөө үед үргэлжилж болох зарим нэг чухал зүйлсийг үзэцгээе.

## ҮРГЭЛЖИЛЭХ ЗҮЙЛС

Бид энэ хоёр үед хамаарах Христэд итгэгчдийн хооронд үргэлжилсээр байгаа зүйлсийг ингэж хураангуйлж болох юм. Бид Эцэг, Хүү, Ариун Сүнс хэмээн Гурвалаар оршин байдаг нэг л Ертөнцийн Эзэнд итгэдэг. Бид Христээр дамжуулан байгуулах Ертөнцийн Эзэний хаант улс гэсэн нэг л зорилготой. Мөн бид Христэд итгэж, гэмт амьдралаа орхиж, дуулгавартай байхыг шаарддаг аврал болон гэмийн боолчлолоос чөлөөлсөн Христийн чөлөөлөлтын тухай нэг л сайн мэдээнд итгэдэг. За одоо бүгдээрээ 1-р зуунд амьдарч байсан Христэд итгэгчидтэй адил нэг л Ертөнцийн Эзэнд бид итгэдэг гэсэн баримтыг судалцгаая.

## Нэг л Ертөнцийн Эзэн

Авралын түүхийн тухай өгүүлсэн Луухын энэ тэмдэглэл нь Есүсийн төлөөлөгчид болон эхэн үеийн итгэгчдийн үйлчилж байсан тэр л Их Эзэн Есүс Хрисэд бид үйлчилж, Түүнийг гэрчилж байгааг маань бидэнд сануулдаг. Христэд итгэгч хүн бүр 1-р зууны үед байсан тэр л Ариун Сүнснээс эрх мэдлийг хүлээн авсан юм. Бид нэг л ер бусын Эцгийг алдаршуулж хүндлэн дээдлэхийн тулд бүхнийг хийдэг билээ. Гурвал байдлаар оршигч Ертөнцийн Эзэн маань хэзээ ч өөрчлөгдөөгүй.

Ертөнцийн Эзэн 1-р зуунд Сайн мэдээгээр дамжуулан гайхалтай арга замаар ажиллаж байсан бол Тэрбээр өнөөдөр ч гэсэн яг л тийм арга замаар ажилласаар л байна. Хэрэв Ертөнцийн Эзэн таны амьдралаас таны сүмээс эсвэл дагадаг

Христийн урсгалаас тань хол хөндий юм шиг санагдаж байгаа бол, тийм байх ёсгүй юм. Ертөнцийн Эзэн ажиллаж байгааг олж харахгүй байгаа бол, алдагдсан хүмүүст авралыг өгч, өөрийнхөө сүмийг байгуулахгүй байгаа бол бид Түүнд дахин хандаж, итгэж найдан, гэмт амьдралаа орхиж, бидний амьдрал болон сүмд маань авралын түүхэнд хийж буй энэрлийн ажлаа үргэлжлүүлэн хийхийг Түүнээс хүсэх хэрэгтэй.

Христэд итгэгчид нэг л Ертөнцийн Эзэнд итгэдгээс гадна Үйл явдал номонд өгүүлсэн Христийн сүмийн өмнө тавигддаг нэг л зорилготой билээ.

## Нэг л зорилго

Үйл явдал номонд, Төлөөлөгчдөөр дамжуулан Христэд итгэсэн хүмүүсээр хаант улсаа байгуулах нь Ертөнцийн Эзэний зорилт байсан тухай өгүүлдэг. Тэд энэ зорилгыг биелүүлэхийн тулд сүмд туслан Сайн мэдээгээр дамжуулан итгэгчдийн тоог өсгөж байлаа. Гэхдээ тэд бас Ертөнцийн Эзэний хаант улсыг өргөжүүлж, энэ дэлхийн өнцөг булан бүрт хүргэхийн тулд арав гаруйхан хүн хэдхэн жил ажиллаад хийчих ажил биш гэдгийг мэдэж байсан. Тиймээс тэд Христэд итгэгчидтэй тусгайлан ажиллаж, өөрсдийг нь нас барсаны дараа энэ үйлсийг үргэлжлүүлэхэд тэднийг бэлтгэж байв. Есүс хаант улсаа байгуулах даалгаврыг Төлөөлөгчдөд өгсөн бол Төлөөлөгчид энэ даалгаврыг сүмд өгсөн юм гэж үүнийг бид хэлж болно.

Мэдээж хаант улс байгуулах энэ зорилго Христийг яруу алдраа дуурьсган эргэн иртэл биелэж дуусахгүй билээ. Тэгэхлээр орчин үеийн сүмийн зорилго бол Христээр дамжуулан ер бусын хаант улсаа байгуулах гэсэн Ертөнцийн Эзэний ажил хэрэгтэй нийцэж, бүх дэлхий даяар хүн бүрийг Их Эзэн Христийн дор аваачих явдал хэвээрээ л байна. Энэ бүхнийг хийх хамгийн эхний арга зам бол аврал, ёс зүй, Ертөнцийн Эзэний адил зан чанар, харилцаа, авралын зар тараах гэх мэт хүний амьдралын бүх асуудлын талаар Есүсийн төлөөлөгчдийн сургаалд итгэн найдах явдал билээ. Тэгээд ч бид Христийг хүндэлж Түүнд дуулгавартай байхыг хүсэж л байгаа юм бол Түүний төлөөлөгчдийн эрх мэдэлтэй гэрчлэлд захирагдах ёстой.

Жишээлбэл, Төлөөлөгчид энэ хаант улсыг янз бүрийн соёлтой улс орон болон нөхцөл байдал дунд өөр өөр арга замаар өргөжүүлж байгааг Луух тун няхуур бичиж тэмдэглэсэн байдаг. Бид тэдний жишээг дагаж өөрсдийн амьдарч байгаа үедээ ер бусын хаант улсын зорилгыг урагш ахиулахын тулд ижил төстэй арга хэрэгслийг хэрэглэж чадна. Мэдээж бид орчин үе болон эртний дэлхий ертөнцийн хоорондох үл үргэлжилэх зүйлсийг харгалзан үзэж зохих зохицуулалтыг хийх шаардлагатай. Бид өөрсдийн хөтөлбөрт бус, энд дурдсан Ертөнцийн Эзэний ажил хэрэгт захирагдсан цагт л үүний ард буй зорилго болон зарчмууд хүн төрөлхтөний үе бүрд нэг ижил байж чадна.

Эцэст нь орчин үеийн итгэгчид нэг л Ертөнцийн Эзэнд итгэж, нэг л Зорилготой байснаас гадна 1-р зууны үеийн сүмтэй адил нэг л Сайн мэдээг тунхаглахаар дуудагдсан юм.

## Нэг л Сайн мэдээ

Энэ дэлхий ертөнц хэдий чинээ их өөрчлөгдсөнөөс үл хамаараад нэг зүйл огт өөрчлөгдөггүй. Хүмүүс гэм хийж Ертөнцийн Эзэнийг эсэргүүцэн босож, Түүнээс тусгаарлагдсан учраас гэмийн боолчлолоос чөлөөлөгдөх зайлшгүй шаардлагатай болсон. Бид бүгдэд нэг л аврал хэрэгтэй. Харин энэ аврал Христэд итгэсэн цагт л боломжтой болдог юм. Тэрбээр бидний гэмийг уучилж, хаант улсдаа оруулдаг. Энэ бол 1-р зууны үед Төлөөлөгчдийн зааж байсан сайн мэдээ билээ. Энэ бол Үйл явдал номонд Луухын тунхагласан сайн мэдээ юм. Энэ бол өнөөдөр ч гэсэн бидний хүлээн авч захирагдах ёстой сайн мэдээ билээ.

Харин энэ маань тун энгийн мэдээ байдаг. Энэ мэдээ бол Үйл явдал номын 16-ийн 31-д Пууль Силас хоёрын Филипой хотын шоронгийн харгалзагчид хэлсэн:

Та, гэр бүлийнхээ хамт Есүс Их Эзэнд итгэвэл гэмээ цагаатгуулж аврагдах болно (Үйл явдал 16:31).

Энэ энгийн мэдээ нь гүн гүнзгий утга учиртай. Бидний хувь хүний болон хамт олон дундахь амьдралын бүх талыг энэ мэдээ хамарч, биднийг хувиран өөрчлөгдөж, хүн төрөлхтөний дунд сайн мэдээний гэрч болоход уриалан дууддаг юм.

Энэ сайн мэдээ нь бүх газар нутагт бүх цаг үед амьдарч байгаа бүх хүний хувьд адилхан хэвээрээ л байна. Бүх хүн Ертөнцийн Эзэнийг эсэргүүцсэн гэмт амьдралаа орхиж Христэд итгэхээр дуудагдсан билээ. Бүх хүн Түүнийг Их Эзэнээ болгон захирагдаж хаант улсыг нь байгуулах ёстой. Төлөөлөгчдийн амьдарч байсан үеэс эхлээд дэлхий даяар энэ сайн мэдээг тунхаглаж байсаны адил өнөө үед хүн бүрт энэ дуудлага очих ёстой юм шүү. Дуулгавартай байх дуудлага нь Еврейчүүд, Еврей бус хүмүүс, баян, ядуу, эрэгтэй эмэгтэй, алдар хүнтэй эсвэл адлагдаж доромжлогдсон бүх хүнд хамаатай байдаг. Энэ нь бүх төрлийн эсэргүүцэл, саад бэрхшээлийг даван туулдаг. Энэ бол Ертөнцийн Эзэн Эцгийг алдаршуулахын тулд Ариун Сүнсний олгосон эрх мэдлийг ашиглаж Христийн ноёрхолыг тогтоох үг юм. Үйл явдал номонд заасны дагуу гэмийн боолчлолоос чөлөөлөх энэ авралыг эсэргүүцэж чадах ямар ч бэрхшээл, зовлон зүдгүүр, эсэргүүцэл байдаггүй билээ. Тийм учраас л орчин үеийн итгэгчид Төлөөлөгчдийн заасан сайн мэдээг хүлээн зөвшөөрч, чин сэтгэлээсээ зоригтой тунхаглаж, хүн бүрийг гэмт амьдралаа орхиж Христэд итгэхийг уриалж, улмаар тэднийг Ертөнцийн Эзэний хаант улсын үнэнч шударга иргэд болгох хэрэгтэй.

## ДҮГНЭЛТ

Бид энэ хичээлээр Үйл явдал номонд Луухын хэрэглэсэн уран яруу өгүүлэх арга барил, уг номын агуулга болон түүний сургаалийг орчин үед хэрэгжүүлэхэд тохирох эхний алхамын талаар судаллаа. Энэ бүх асуудлыг судалсан маань бидэнд түүний эрх мэдэлтэй сургаалийг өөрсдийн амьдарч байгаа үед хэрхэн ойлгож, хүлээн авч, амьдрах арга замаар хангах ёстой.

Үйл явдал ном нь олон талаараа Христийн амьдарч байсан үе болон орчин үеийн сүмийн хооронд буй хаалганы үүрэг гүйцэтгэдэг. Энэ нь Христ хүн болж ирээд хийж гүйцэтгэсэн ажил, заасан сургаалыг эхэн үеийн итгэгчид хэрхэн ойлгож хэрэгжүүлж байсан талаар тайлбарлаж, улмаар энэ бүхнийг өнөөгийн Христэд итгэгчид хэрхэн ойлгож амьдралдаа хэрэгжүүлэх үндсийг тавьсан билээ. Тийм учраас бид Үйл явдал номонд өгүүлж буй Луухын зорилго болон арга барилыг аль болох сайтар ухаарах тусмаа, дахин амилсан Хаанаа илүү сайн хүндэлж Түүнд улам сайн үйлчилж амьдрах талаар сайтар бэлтгэгдэж чадна.

---

**Др. Ханс Ф. Байер (Host)** is Professor of New Testament and Chair of the New Testament Department at Covenant Theological Seminary in St. Louis, Missouri. Dr. Bayer received his M.A. and M.Div. from Ashland Theological Seminary, and his Ph.D. from University of Aberdeen in Scotland. Born and raised in Germany, Dr. Bayer taught for ten years at the German Theological Seminary at Giessen, where he also planted and co-pastored a church. He lectures and preaches regularly throughout the U.S. and Europe and has published numerous English and German monographs, essays, dictionary articles, and commentaries, primarily on the Gospels and the Book of Acts. He is also the author of *A Theology of Mark: The Dynamic Between Christology and Authentic Discipleship* (P&R, 2012).

## ТАЙЛБАР ТОЛЬ

---

**Ананай** – Эхнэр Сафейрийн хамт газраа зараад олсон мөнгөө төлөөлөгч нарт өгөхдөө тоо дүнг нь худал хэлсэн эр. Тэд хоёул шийтгэл хүлээн газар дээрээ үхсэн. (Үйл явдал 5)

**Аполь** – Маш чадварлаг Еврей багш, илтгэгч. Тэрээр Пуультай хамт ажиллаж анхны сүмийн өсөлтөнд хувь нэмэр оруулж байсан. Ялангуяа Эфэс болон Коринф хотод төвлөрсөн

**баталсан хэлбэрийн яриа** – Зохиогч уншигчиддаа шууд хандан ярих хэлбэрийн утга зохиол дахь харилцан ярианы хэлбэр. Энэ аргаар аливаа санааг шууд бөгөөд ил тод илэрхийлдэг

**Хорнел** – Цезаре хот дах Ромын цэргийн ангийн захирагч. Тэрээр Пуулийн үйлчлэлийн үр дүнд Христэд итгэсэн юм. (Үйл явдал 10–11)

**Барисос** – Кипр арлын бөө. Түүнийг гайхамшигтайгаар сохор болгосны үр дүнд тус арлын захирагч сайнмэдээнд итгэдэг. (Үйл явдал 13)

**хэсэг хэсгээс бүрдсэн** – ар араасаа дараалан орсон олон жижиг түүх, тэмдэглэлийн цуглуулга

**хүүрнэсэн хэлбэрийн яриа** – Түүх өгүүлж, аливаа сургаалийг шууд бус аргаар ойлгуулахыг зорьсон утга зохиолын хэлбэр

**Филипп** – Иерусалимийн сүмийн туслагч. Шомрон аймагт сайн мэдээг тунхаглаж олон хүнийг Есүст итгүүлсэн хүн. Тэдний дотор Этиопын сайн ч багтдаг. Энэ хүн Есүсийн төлөөлөгч Филип биш

**Присхил** – Энэ эмэгтэй өөрийн нөхөр Ахуулийн хамт Эфэсийн Апольд зөвлөгөө өгсөн

**Симун** – Ариун Сүнсний хүч чадлыг худалдаж авч болдог гэж бодсон Шомрон аймгийн нэг бөө